



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 - 57

- 1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/* 9 - 10
 - 2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай/* 10
 - 3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 10 - 11
 - 4. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/* 11
 - 5. Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан* 11 - 40
 - 6. Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан* 40 - 57
-

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 05-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баделхан, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунчимэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Аж ахуйн нэгжсийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга П.Оюунчимэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын дарга Б.Даваасүрэн, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Цогтжаргал, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга Б.Буяннэмэх, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга Д.Сайханчулуун, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэг, Гаалийн ерөнхий газрын Татвар, тарифын газрын гаалийн улсын ахлах байцаагч Б.Эрдэнэбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Батчимэг, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор Э.Энхбаатар, мөн газрын аудитор Б.Мөнхтуяа, Мэдээллийн технологийн төвийн шинжээч Д.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан

хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын дарга Б.Даваасүрэн, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Цогтжаргал, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга Б.Буяннэмэх, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга Д.Сайханчулуун, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэг, Гаалийн ерөнхий газрын Татвар, тарифын газрын гаалийн улсын ахлах байцаагч Б.Эрдэнэбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Батчимэг,

Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор Э.Энхбаатар, мөн газрын аудитор Б.Мөнхтуяа, Мэдээллийн технологийн төвийн шинжээч Д.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, А.Хонгорзул нар байлцав.

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт болоод гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлангийн танилцуулгыг Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 42 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд С.Одонтуяа гишүүн, Д.Тогтохсүрэн гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Б.Жавхлан гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Л.Мөнхбаатар нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Төсвийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Байнгын хорооны хурал тогтоолын төсөл. Цаглавар батлах тухай байгаа. 12 сарын.

Хоёр. Байнгын хорооны тогтоолын төсөл.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай асуудал.

Гурав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газрын 2023 оны 10 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан эцсийн хэлэлцүүлэг.

Тав. Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний өрнөлийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх.

Үндэсний аудитын газар 09 сарын 29-ний өдөр ирүүлсэн.

Зургаа. Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх.

Аудитын газар 09 сарын 20-ны өдөр ирүүлсэн.

Хэлэлцэх асуудтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
*/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сард хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай/*

Нэгдүгээр асуудал. “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 12 сард хэлэлцэхээр заасан асуудлаар Байнгын хорооны цаглаварын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны нисэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

Байнгын хорооны гишүүдийг дуудаарай.

Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ц.Даваасүрэн гишүүн горимын санал гаргая.

Ц.Даваасүрэн: Миний төхөөрөмж жоохон алдаатай болчихлоо. Дахиад

санал хураалгаж өгнө үү. Би уг нь дэмжсэн байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ц.Даваасүрэн гишүүний саналаар өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Дахиад уначихлаа. Тийм ээ. Ж.Батсуурь гишүүн горимын санал гаргая.

Ж.Батсуурь: Энэ алдаа заагаад байна. Дахиж санал хурааж өгнө үү?

Г.Тэмүүлэн: Тэгье. Ж.Батсуурь гишүүний саналаар санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Б.Жавхлан гишүүн горимын санал гаргая.

Б.Жавхлан: Ёстой уучлаарай. Би өөрөө хариуцлагагүй байсан байна. Санал бол дэмжсэн шүү. Мэдээж. Уучлаарай.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайдын саналаар санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Б.Жавхлан сайдын санал хураалт дэмжигдсэн тул Төсвийн байнгын хорооны 12 сард хэлэлцэх асуудлын цаглаварыг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

С.Одонтуяа гишүүнийх орсон уу?
Түр хүлээж байя. Санал хураалтыг явуулъя. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Санал 70.0 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай/

Хоёр. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд Байнгын хорооны тогтоолын төслийг тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд анхааралтай байгаарай.

70.0 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Гурав. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олгохын дэмжлэг авсан

саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болоод хуулийн төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Ж.Батсуурь гишүүн танилцуулъя.

Ж.Батсуурь гишүүн танилцуулна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсантай холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Дөрөв. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлбэ. Улсын Их Хурлаас 2023 оны 07 сарын 07-ны өдөр баталсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан тогтоолын төсөл байгаа.

тогтоолын төсөлд нэмж тусган хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг Та бүхэн тараасан байгаа.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан

Тав.Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Тав дахь асуудлыг хэлэлцэж эхэлбэ.

гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж эхэлбэ.

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний өрнөлийн талаар

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хуралдаанд оролцуулаарай. Танилцуулж

байя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Татварын ерөнхий газрын дэд дарга А.Энхболд, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Н.Эрдэнэ, Сангийн яамны Орлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын дарга Б.Даваасүрэн, Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Цогтжаргал, Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга Б.Буяннэмэх, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга Д.Сайханчулуун, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн хэлтсийн дарга Н.Мөнхбилэг, Гаалийн ерөнхий газрын Татвар, тарифын газрын гаалийн улсын ахлах байцаагч Б.Эрдэнэбат, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Батчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор Э.Энхбаатар, Үндэсний аудитын газрын Аудитын

нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитор Б.Мөнхтуяа, Үндэсний аудитын газрын Мэдээллийн технологийн төвийн шинжээч Д.Энхтуяа гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Аудитын тайлангийн танилцуулгыг Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг дарга танилцуулна.

Ц.Наранчимэг даргын микрофоныг өгье. 3 номер байна.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хорооны баталсан аудитын сэдвийн хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхэд хамрах асуудлаар аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитыг хийхийн тулд дараах гурван зорилгыг хангах дэд зорилтын аудитыг хийж гүйцэтгэсэн болно.

-Татварын шинэчлэлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийцүүлж боловсруулсан эсэх;

-Татварын хуулийн шинэчлэл нь төрийн санхүү, төсвийн бүрдүүлэлт болон нийгэм, эдийн засагт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитад Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, тэдгээрийн харьяа хэлтэс, зарим

байгууллагын 2019-2022 оны үйл ажиллагааг түүвэрчлэн хамрууллаа.

Аудитад хамрагдсан 2019-2022 онд дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар цар тахлын нийгэм, эдийн засагт болон татвар төлөгчдийн үйл ажиллагаанд үзүүлсэн сөрөг нөлөөллөөс үүдэж татварын бодлого, хуулийн шинэчлэлийн хэрэгжилт, үр нөлөөг бодитоор хянаж, тооцох боломжийг алдагдуулж, аудитын үр дүн, чанарт нөлөөлөх эрсдэлтэй байсныг дурдах нь зүйтэй болно.

Монгол Улсад орчин цагийн татварын тогтолцоо 1990 онд бүрдэж, 1992 онд Татварын албаны тухай хууль болон Татварын багц 5 хууль батлагдсан байна.

Улсын Их Хурлаас 2019 онд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж баталснаар татварын шинэчлэл хэрэгжиж эхэлсэн байна.

Татварын шинэчлэл нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолоор баталсан Гурван тулгуурт хөгжлийн бодлого болон эдийн засгийг дэмжих санхүү, төсвийн бодлогын хүрээнд төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд татварыг бүрэн хураах, татвар төлөгчдийг дэмжих зорилт, татварын хувь хэмжээг нь нэмэгдүүлэхгүй байх, жижиг, дунд татвар төлөгчдийн төлөх татварын хувь хэмжээг бууруулж, татварын бааз суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг

бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан татварын үйл ажиллагааг зохицуулсан 8 арга хэмжээнээс 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ гэсэн хөтөлбөрийг хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан байна.

“Гурван тулгуурт” хөгжлийн бодлогоор

27 зорилтын хүрээнд 149 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс

- 79 арга хэмжээг **“үр дүнтэй”**,
- 48 арга хэмжээг **“тодорхой үр дүнд хүрсэн”** буюу 70 хувь,
- 21 арга хэмжээг **“эрчимжүүлэх шаардлагатай”** буюу 40 хувийн хэрэгжилттэй гэж

Үндэсний хөгжлийн газраас 2019, 2020 онуудыг хамруулж үнэлсэн бөгөөд бодлогыг хэрэгжүүлэх хугацаа дууссан байна.

Аудитаар үнэлгээг дахин нягтлахад ажлын байр олноор бий болгоход татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх зорилтын хэрэгжилт үр дүн тодорхойгүй байна.

Татварын шинэчлэл болон тухайн жилийн төсөвт баримтлах татварын бодлогыг Монгол Улсын 2019, 2020, 2021, 2022 оны төсвийн тухай хуулийн

үзэл баримтлалд тусгаж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан боловч хэрэгжүүлэгч байгууллага хүрэх үр дүнг нь тодорхой тусгаагүй байна.

Татварын үйл ажиллагаанд мөрдөх дунд хугацааны стратеги болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Сангийн яам, Татварын ерөнхий газар тус улс баталж хэрэгжүүлэх арга хэмжээ авч, харилцан адилгүй Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-д Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг уялдуулан батлах гэж заасны дагуу бодлогын баримт бичгийн уялдааг сайжруулж, үнэлж дүгнэх шаардлагатай байна.

Татварын эрх зүйн шинэчлэл, татварын хувь хэмжээ, татварын тайлагналын тоог бууруулж хялбаршуулах, татвар төлөгч, татварын албаны эрх үүргийг тэнцвэржүүлэх, татварын багц хуульд олон улсын татвар төлөгчдийн харилцаа, үнэ шилжилтийн асуудлуудыг тусгаж, хэрэгжүүлж ажиллаж байна.

Татварын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, хөрөнгө оруулагч, олон улсын байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийн саналыг авч хуулийн шинэчлэл найруулгад туссан нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн байна.

Улсын Их Хурлаас 2019 онд Татварын хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдсөн бөгөөд тус

хуулийг дагуулан 28 төрөлжсөн хуулийн татварын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Татварын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах үүднээс Сангийн сайдын баталсан 26 дугаар журам Татварын ерөнхий газрын баталсан нийтээр дагаж мөрдөх 51 захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулсан байна.

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой Гаалийн ерөнхий газарт **13.9** тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **25.9** тэрбум төгрөгийн албан шаардлага, Татварын ерөнхий газарт **5** зөвлөмж, Сангийн яаманд **3** зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Аудитын дүнд үндэслэн анхаарвал зохих асуудлаар дараах дүгнэлтүүдийг өгч байна.

- Татварын багц хуулиудыг шинэчлэн баталж, холбогдох **28** хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлж байгаа боловч холбогдох зарим татварын хуулиудыг уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.
- Татварын хуулийн шинэчлэлээр татварын хувь хэмжээг шатлан бууруулах, жижиг болон бичил бизнесийг дэмжих, хүн амын төвлөрлийг сааруулах, эдийн засгийн хямрал, КОВИД-19 цар тахлын үед иргэд, аж ахуйн

- нэгжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, татварыг цахимжуулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилт тавьж хэрэгжүүлснээр татварын бааз суурь өргөжиж, улсын төсвийн орлогын 70 гаруй хувийг татварын орлогоос бүрдүүлж байна.
- Корона вируст цар тахлын нийгэм, эдийн засаг болон татвар төлөгчдийн үйл ажиллагаанд үзүүлсэн сөрөг нөлөөллөөс үүдэж татварын бодлого, хуулийн шинэчлэлийн хэрэгжилт, үр нөлөөг бодитоор хянаж, үнэлэх боломжийг хязгаарлаж байна.
 - Нийгэм, эдийн засаг, иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй татварын нөлөөлөлд үнэлгээ хийх, татварын ачааллыг салбар, сегментийн хэмжээнд тооцон дүн шинжилгээ хийх замаар төсвийн бодлогыг татварын бодлоготой уялдуулж, эдийн засгийг жигд өсөлтөд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
 - Хувиараа бизнес эрхлэгч болон жижиг бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, татвар ногдуулалт, хураалт, цахим и-баримт олголт нь хангалтгүй байгаа нь бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгчдийн хэмжээнд далд эдийн засгийг бууруулах зорилтод сөргөөр нөлөөлж байна.
 - Татварын өрийн үлдэгдэл 2019 онд 2.8 дахин өсөж, 3 их наяд 276.6 тэрбумд хүрсэн нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал КОВИД-19 цар тахлын үед хууль эрх зүйн хүрээнд татвар төлөлт, ноогдуулалтыг хойшлуулсан зохицуулалтыг хэрэгжүүлснээр шалтгаалжээ.
 - Татварын албадан гүйцэтгэх үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд бусад салбарын хуулиудтай уялдаа сул байгаагаас үр дүнд хүрч чадахгүй байна.
 - Татварын хуулийн шинэчлэлийн хүрээнд мэдээлэл технологийн системийн хөгжүүлэлтийг хийж, татварын эрсдэлийн удирдлага болон судалгаа, шинжилгээний ажлыг бодит цагийн горимоор хэрэгжүүлснээр хяналтыг үр дүнтэй зохион байгуулах боломж бүрдсэн байна.
 - Татварын хуулийн шинэч ажилтай уялдуулж мэдээлэл авах эрх зүйн орчин сайжирсан ч эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгууллагынхаа албан
-

тушаалтанд төрийн болон албаны нууцтай танилцах эрх олгож байгаа зөрчил байна.

холбогдох хуульд нийцүүлэн журамд өөрчлөлт оруулж, мөрдөж ажиллах.

Аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сангийн яаманд:

- Татварын ерөнхий хуульд заасан татварын хуулиудыг Гаалийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн тухай хууль, Автотээврийн болон өөрөө явж хэрэгслийн тухай хууль, татварын шинэчлэлийн шаардлагад нийцүүлж уялдуулах талаар шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Татварын ачааллыг салбар, сегментийн хэмжээнд тооцож, иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бодитоор үнэлж, дүн шинжилгээ хийх, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг баталж хэрэгжүүлэх, татварын эдийн засгийн жигд өсөлтөд дэмжлэг үзүүлж тогтворжуулах чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;
- Төсвийн бодлогыг татварын бодлоготой уялдуулан төлөвлөж, татварын орлогыг улс болон орон нутгийн төсөвт хуваарилах талаар

Татварын ерөнхий газарт:

- Хувиараа болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, ногдуулалт, хураалтыг хүртээмжтэй зохион байгуулах и-баримтын олголтоор дамжуулан тавих хяналтыг сайжруулах;
- Хуримтлагдсан болон эргэн төлөгдөлтөд хүндрэл учирсан татварын өрийг барагдуулах талаар бодитой арга хэмжээ авах;
- Татварын албадан гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг сайжруулах, салбар хоорондын уялдааг хангах замаар үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Татварын үйл ажиллагааг мэдээлэл технологийн дэвшилттэй уялдуулан бодит цагийн горимоор оновчтой зохион байгуулж, дэвшилтэт технологийг төрийн бусад байгууллагуудад таниулж, мэдээлэл солилцож байх;
- Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалахад анхаарч, холбогдох хуулиудыг мөрдөж ажиллах гэсэн зөвлөмжийг хүргүүлж

байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ц.Наранчимэг даргад баярлалаа.

Тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

С.Ганбаатар гишүүнээр тасалъя.
С.Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би сүүлийн үед аудитын фен болчхоод байгаа шүү дээ.

Энэ манай яг Их Хурлын нүд чих болсон аудит сайн ажиллаж байгаа. Тэгэхээр аудитын гаргасан дүгнэлтийг Засгийн газар, Улсын Их Хурал яг хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдэг асуудал л бидний тулгамдсан асуудал болчхоод байгаа.

Маш их бэрхшээлүүд дундуур эд нар гаргадаг биз дээ бодвол. Тэгээд л дарамт байгаа шүү дээ.

Нэгдүгээр асуулт.

1.1.4. Хуудас 11. “Хүн амын өсөлтийн бодлогын хүрээнд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлт үзүүлнэ.” гэсэн маш чухал заалт байгаа. Үүнийг яагаад хойшлуулчав аа?

Энэ хойшлуулсан шалтгаанаа тайлбарлаж аятайхан ярьдаг юм болов уу? Юу гэж тайлбарлаж байна?

Хоёрдугаар асуулт.

Хуудас 15. 2.2.2. Монгол Улсын татварын ачаалал нь 29.2 хувьд хүрсэн.

Татварын ачаалал 29.2 хувьд хүрчихсэн. Олон улсын татварын ачааллын дундаж хэмжээнээс. Дундаж нь 20.8 байдаг л даа. 8.4 нэгжээр бүр нэмэгдчихсэн. Олон улсын дунджаас.

Ази, Номхон далайн, ер нь Азийн орнуудын дундаж 21 хувь байдаг. Арай их байдаг. Тэрнээс 8.2 нэгжээр өндөр байна.

Энэ юунаас болоод ингэжхэв ээ? Инфляцаас болоод би татвараа нэмчихэв үү? Татвар өндөр авч байна уу? Татварын ачаалал яачхав?

Ардын нам чинь татвар дээр жаргаана л гээд байсан шүү дээ. Тэр жаргал хаа байна аа?

Дараагийн асуулт. Икс тайлан гаргадаг аж ахуйн нэгжийн тоо 20.7 мянгаар нэмэгдсэн гэж байна. Үндсэндээ аж ахуйн нэгжүүдэд бид чирч унагаж байна шүү дээ. Аж ахуйн нэгжүүд үндсэндээ амьдрах аргагүй болж байна шүү дээ. Энэ чинь ажлын байрыг аж ахуйн нэгжүүд бий болгодог. Улс төрчид бий болгодоггүй байхгүй юу даа. Харин улс төрчид аж ахуйн нэгжүүдэд үйлчлэх үүрэгтэй.

Тэгэхээр би хэнээс асуух ёстой юм. Үүний цаад углуурга шалтгаанууд. Нөхцөл байдал ийм байна. Гарсан үр дүн ийм байгаа. Зүгээр тайлбар нь юу гэж хэлдэг юм бол? Үүнийг удахгүй засна. Эсвэл та нар буруу харсан байна. Юу гэж хэлдэг юм бол? 20.7 гэдэг чинь маш их тоо. Нийт татвар төлөгчдийн 32.2 хувь шүү дээ. Үгүй ээ мөн.

Нийт татвар төлөгчдийн 3 хүний нэг нь икс тайлан гаргаж байна шүү дээ.

Ашиг орлогогүй. Дампуурсан гэсэнтэй адилхан.

Тэгээд далд эдийн засаг аймшигтай өссөн. Далд эдийн засаг дээр энэ дээр харин нэг аюултай юм явчих юм. Далд эдийн засгийг бууруулах талаар татварын аягүй гайгүй бодлого хэрэгжүүлсэн гээд нэг үг явсан. Тэгсэн далд эдийн засаг өссөн тоо энэ дээр сая байсан.

Тэгэхээр миний сая тодруулж байгаа зүйлүүд аж ахуйн нэгжүүдийг нэлээн хүнд байдалд оруулчихсан гэдэг ийм аудит гарсан байна. Үүний шалтгаан, үр дагавар, хойшид үүнийгээ засаж залруулах талаар ямар төлөвлөгөө, хөтөлбөр та нар дээр ирсэн бэ? Холбогдох тэр байгууллагуудаас нь ирсэн бэ гэж тодруулья.

Г.Тэмүүлэн: С.Ганбаатар гишүүн дөрвөн асуулт асуулаа.

Эхлээд аудитын тайлантай холбогдуулаад Ц.Наранчимэг дарга та эхлээд байр сууриа илэрхийлээч. 3 номер. Дараа нь холбогдох албан тушаалтнууд, Сангийн яам, Татварын ерөнхий газрууд нэмэлт тайлбаруудыг өгөөрэй. Ц.Наранчимэг даргын микрофон.

Ц.Наранчимэг: С.Ганбаатар гишүүний асуултад хариулья. Үндэсний аудитын газар Ц.Наранчимэг байна.

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажихаас нь өмнө Төрийн аудитын тухай хуульд заасан 10 хоногийн хугацаанд шалгагдагч буюу аудит аудитад хамрагдагч этгээдэд танилцуулж, саналыг нь авч, тайланг эцэслэн гаргадаг.

Тэгэхээр тайланд гарсан асуудалтай бол тайланд хамрагдсан

байгууллагууд асуудлыг хүлээн зөвшөөрч тайланг баталгаажуулж гаргасан.

Нотлох баримтын хүрээнд бид санал зөрж байгаа асуудлыг аудитын багтаа дахиж нягтлах хуулийн зохицуулалттай. Энэ зохицуулалтын хуулиа хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан татварын үйл ажиллагааг зохицуулсан 8 арга хэмжээнээс 7 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. Тайланд байгаа.

1 арга хэмжээ нь хэрэгжүүлээгүй. Саяын таны асуусан 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд хүүхдийн тооноос хамаарсан хөнгөлөлт үзүүлнэ гэсэн.

Энэ асуудлыг тайлбарлахдаа хөтөлбөрийг хойшлуулсан асуудал нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрх бүрд олгож байгаа энэ асуудалтай давхардаж байгаа учраас татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хойшлуулсан гэсэн асуудлыг аудитын тайланд тусгасан байгаа.

Ковид, коронавируст тар тахлын үед нийгэм, эдийн засаг болон татвар төлөгчдийн үйл ажиллагаанд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, татварын хуулийн шинэчлэлийн хэрэгжилтийг бодитоор үнэлж хянахад аудитын явцад хүндрэлтэй байсан.

Монгол Улсад өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн “икс” тайлан гаргаад байгаа асуудал нь орлогыг үнэн зөв, бодитой төлөвлөх, далд эдийн засгийг бууруулахад сөргөөр нөлөөлж байгаа.

Тийм учраас аудитын тайлангаар Сангийн яаманд татварын ачааллыг салбар сегментийн хэмжээнд нь тооцож, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бодитойгоор үнэлэх, дүн шинжилгээ хийх, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг баталж хэрэгжүүлэх, татварын эдийн засгийг жигд өсөлтөд дэмжлэг үзүүлж, тогтворжуулах чиг үүргийн хэрэгжилтийг хангуулахад зайлшгүй арга, аргачлал шаардлагатай байгаа учраас энэ ажлыг хийхийг Сангийн яаманд зөвлөмжөөр хүргүүлсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Ц.Наранчимэг дарга хариулаа. Сангийн яамнаас Б.Заяабал дарга тайлбар өгөх үү? 7 номер.

Б.Заяабал: Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе.

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал байна. С.Ганбаатар гишүүний асуусан гурван асуулт дээр би хариулъя. Нэмэлт тодруулга хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, татварын ачаалал **20.8-аас 29.2** болоод **8.4** пунктээр нэмэгдчихлээ гэдэг ийм асуудал асуулаа.

Тэгэхээр аудитын байгууллагаас шалгасан шалгалтын дүнд бичсэн “татварын ачаалал” гэдэг үг нь өөрөө бас жоохон буруу сонгогдчихсон юм болов уу гэж бодож байна.

Олон улсад **tax ratio**_[татварын харьцаа] буюу **Tax-to-GDP** гэдэг үзүүлэлтээр “татварын нийт орлого нь тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувийг эзэлж байна вэ” гэдгийг тооцдог үзүүлэлт байдаг.

Яг “татварын ачаалал” гэж тооцох **tax burden**_[татварын дарамт] гэдэг үзүүлэлтээр тооцдог. Энэ хоёр үзүүлэлт хоёр өөр юм гэдгийг хэлье.

Tax-to-GDP буюу “дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын тоо хэмжээ” нэмэгдэж байна гэдэг бол үүний цаана далд эдийн засаг буурч байгаа гэсэн үзүүлэлт.

Татвар, өөрөөр хэлбэл “хуулийн хэрэгжилт сайжирснаар төсөвт орж ирэх татварын орлого нэмэгдэж байна” гэсэн утгатай юм гэдгийг бас энд хэлье.

Tax burden буюу “татварын ачааллыг тооцдог арга, аргачлал” тусдаа байдаг. Олсон орлого GDP-ийн хэдэн хувийг эзэлж байна вэ гэдгээрээ татварын ачааллыг тооцдог үзүүлэлт байхгүй гэдгийг нэгдүгээрт хэлэхийг хүсэж байна.

Хоёрдугаарт, далд эдийн засаг өндөр байгаа гэдэг асуудал сая яригдсан.

2.3.2-ыг харах юм бол Монгол Улсад далд эдийн засгийг тооцдог аргачлалыг Үндэсний статистикийн газар хуулиараа гаргадаг. Энэ үзүүлэлтээр далд эдийн засаг

-2018 онд **9.4 хувь**,
-2019 онд **6.3 хувь**,
-2020 онд **5 хувь**,
-2021 онд **4.8 хувь** гээд жил болгон **далд эдийн засаг** буурч байгаа юм.

Далд эдийн засаг буурч байгаа. Үүний нөгөө нөлөөлөл нь GDP-д эзлэх татварын орлого нь нэмэгдэж байгаа юм.

Тэгэхээр үүний цаана далд эдийн засгийг татварын шинэчлэлийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд далд эдийн

засгийг буулгаж байна гэсэн тоо мэдээ манай аудитын тайланд гарсан байгаа гэдгийг бас уялдуулж Та бүхэнд тайлбарлая.

Гуравдугаарт, “икс” тайлангийн тоо нэмэгдэж байна гэдэг асуудал яригдсан.

2.3.8 буюу 17 дугаар хуудсан дээр байгаа. “Икс” тайлангийн тоо нэмэгдэж байна. 70 мянган компани “икс” тайлан өгч байна гэдэг асуудал байгаа.

Хувиар нь аваад үзэх юм бол ер нь жил болгон ирж байгаа тайлангийн үндсэндээ 45 орчим хувь нь “икс” тайлан ирүүлдэг. Энэ тоо хэмжээ жил болгон хэвээрээ байгаа.

Нөгөө талдаа ногдолтой тайлангийн тоо нь бас жил болгон өсөж байгаа. Жил болгон өсөж байгаа.

Тэгэхээр татварын алба татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэх хүрээнд бид цахимжуулсан, **“big data”** үүсгэсэн. **“Машин таниулахуй”** системд бид олон улсын татварын байгууллагуудын хэрэглэдэг **KNIME** [Konstanz Information Miner], **“Neo4j”** гэсэн олон улсын энэ **machine learning** технологиудыг бид үйл ажил ажиллагаандаа ашиглаж эхэлж байгаа. Үйл ажиллагаандаа ашиглаад явж байгаа.

Үүний үр дүнд ирүүлж байгаа тайлангийн үнэн зөв байдлыг татварын байцаагч хуучин хянадаг байсан бол, гар ажиллагаагаар хянадаг байсан бол одоо татварын систем өөрөө хянадаг ийм систем рүү бид шилжсэн байгаа.

Үүний үр дүнд бид энэ ногдолтой тайлангийн тоо хэмжээг нэмэгдүүлсэн байгаа гэдгийг бас энд хэлье.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой зүйл ярихад жилдээ 15-аас 25 мянган хуулийн этгээд жил болгон нэмэгдэж байгаа. Жил болгон нэмэгдэж байгаа. Та бүхэн энэ жилийн нэмэгдлийг аваад тоолоод нэмээд үзэх юм бол жил болгон ийм хурдтай хуулийн этгээдийн тоо нэмэгдэж байгаа.

Г.Тэмүүлэн: 7 номер. Б.Заяабал даргын микрофоныг нэмж өгье.

Б.Заяабал: Тийм. Тэгэхээр энэ хуулийн этгээдийн тоо хурдтай, өндрөөр нэмэгдэж байгаа боловчиг тайлангийн ирц, тайлангийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь тэр хэмжээгээр нэмэгдэж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр бид энэ хуулийн этгээдийн бүртгэлийн процессыг нь бид хялбар болгочихсон боловч эргээд нөгөө хариуцлагын асуудал, татварт ирж тайлагнах, харилцан үүргээ хүлээж явах асуудал хариуцлага хангалтгүй байна гэж үзэж байгаа.

2004 оноос өмнө хуулийн этгээдийн бүртгэл манай татварын албанд байсан. Тэр үед манай тайлан өгөлт, тайлангийн хяналт маш сайн явж байсан юм билээ.

Ингээд Улсын бүртгэлд хуулийн этгээдийн бүртгэл очсоноос хойш хуулийн этгээдэд яг тавигдах шаардлага нь бас суларсан.

Бид Скандинавийн орнуудад татварын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж study tour хийж хурал цуглаанд очиж байх үед туршлагаудыг судалсан.

Тэнд **татварын албаныхаа дэргэд нь хуулийн этгээдийн улсын бүртгэл нь байдаг.**

Татварын албаных нь дэргэд нь хуулийн этгээдийн улсын бүртгэл нь байгаа учраас давхар эздийн, өмчлөгчдийн бүртгэл, эцсийн өмчлөгчдийн бүртгэл нь цуг явж байдаг давуу талууд байдаг юм билээ.

Тэгэхээр хуулийн этгээдийн бүртгэлийн тоо жил болгон 20-оос 30 мянгаар нэмэгдэж байгаа.

Эдийн засагт бодитой хүндрэл учрахгүй байгаа.

Татварын алба араас нь хөөцөлдөж явахтай холбоотой нэмэлт захиргааны зардал гаргах сөрөг тал бас байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: С.Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Би либерал, социал-демократ гэдэг ойлголтыг муухан гадарлана л даа.

Та нар чинь социал-демократ нам шүү дээ. Яагаад нийт аж ахуйн нэгжийн 32.2 хувь нь **“икс”** тайлан өгч байна вэ гэвэл энэ чинь 20.7 мянган аж ахуйн нэгж дампуурлын ирмэг дээр байна гэдэг чинь та нарын татварын бодлого чинь ямар ч социал-демократ биш.

Та нар зүгээр л том том аж ахуйн нэгжүүдэд ээлтэй, тэдэнд долигоносон, пялдганасан тийм татварын тогтолцоотой.

Монгол орон даяар архи үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, подвалд ундаа үйлдвэрлэж байгаа нэг цех

хоёр ижилхэн татвартай байгаа учраас л танайх юун социал-демократ байх вэ дээ.

Яг бодлого нь бол энэ юм байгаа юм шүү дээ.

Тэгэхээр миний цаад санаа нь том том аж ахуйн нэгжүүдээсээ ерөөсөө татвар авч чаддаггүй. Одоо би Монголын татварын зөвлөлийн гомдол гээд 145 гомдол. Дандаа том аж ахуйн нэгжүүд татвараас бултсан.

Ингэхээр нөгөө жижиг аж ахуйн нэгжүүд дээр дарамт нь оччихож байгаа юм.

Тэгээд миний түрүүний ярьсан мэдээллийг би бас дахиад хэлье л дээ.

Далд эдийн засаг 2 их наяд 78 тэрбум төгрөг гэж байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнд далд эдийн засгийн эзлэх хувь 4.8 хувь. Дотоодын нийт бүтээгдэхүүнд шүү дээ. Энэ чинь.

Яагаад далд эдийн засаг бий болж байна вэ гэвэл жижиг аж ахуйн нэгжүүдийг ерөөсөө тоодоггүй, ЖДҮ-нүүдээ анхаардаггүй. Томчуулынхаа кармаанд дандаа ордог оо л гэсэн санаа.

Үүнийг чинь энэ тоо хэлээд байгаа юм. Үүнийг л би хэлээд байгаа юм. Үүнийг бодлого дээр ямар дүрэм, журам байгаа вэ гэж байгаа юм.

Миний асуусан асуултууд нь байна шүү дээ.

Түрүүн аудитаас Гаалийн ерөнхий газарт **13.9** тэрбум төгрөгийн төлбөрийн акт, **28.9** тэрбум төгрөгийн албан шаардлага, Татварын ерөнхий газарт **5** зөвлөмж гаргасан.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Заяабал дарга. Маш тодорхой зүйлүүдийг асууж байна.

Б.Заяабал дарга асуултад хариулъя. С.Ганбаатар гишүүний асуулт. 7 номер.

Б.Заяабал: Татварын ерөнхий газарт аудитын шалгалтын үр дүнд 5 зөвлөмж өгсөн.

Нэгдүгээрт, хувиараа жижиг бизнес, дунд бизнес эрхлэгчдийн татварын тайлагнал, ногдуулалтын хураалтыг зохион байгуулах, и-баримтын олголтоор дамжуулан хяналтыг сайжруулах.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Заяабал дарга. Хариултыг нь 7 номер дуустал нь өгье.

Б.Заяабал: И-баримтын олголтоор дамжуулан тавих хяналтыг сайжруул гэж байгаа юм.

Өнөөдөр бид и-баримтын хөгжүүлэлтийг жил болгон бид хөгжүүлж явж байгаа. Өнөөдөр и-баримтаар дамжуулаад бид эм дээр хяналт тавьж байна, боловсролын систем дээр хяналт тавьж тавьж эхэлсэн байгаа.

Төсвөөс тендер авч ажил гүйцэтгэдэг аж ахуйн нэгжүүд буцаагаад гүйцэтгэлээ авахдаа нэмэгдсэн өртгийн албан татварын и-баримт дээр зайлшгүй баримтаа шивж байж гүйцэтгэлийнхээ буцаан олголтоо авдаг гэх мэтчилэн и-баримтынхаа системүүдийг бид байнга тогтмол хөгжүүлж явж байгаа.

И-баримтын буцаан олголтоороо эргээд жижиг бусад татваруудыгаа төлөх ийм хөнгөлөлттэй боломжийг бид нээж өгсөн байгаа.

Одоо НӨАТ-ын баримтын олголтыг сайжруулах хүрээнд зэрэгцүүлээд бид бараа бүртгэлийн нэгдсэн систем гээд шинэ системийг бид гаальтайгаа хамтраад хөгжүүлээд явж байгаа.

Үүний үр дүнд гаалиар орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүнүүдийг эцсийн хэрэглэгчдэд өгөх, хүртэл очих хүртэл бүх процесс үйл ажиллагаануудыг энэ бүртгэлийн системээр дамжуулж хянах боломж бүрдэж байгаа гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, хуримтлагдсан эргэн төлөгдөх хүндрэл учирсан татварын өрийг барагдуулах талаар бодит арга хэмжээ ав гэдэг ийм чиглэл өгсөн байгаа.

КОВИД-ын үед манай татварын орлого өр нэлээдгүй нэмэгдсэн. Үүнтэй холбоотой бид барагдуулах арга хэмжээг тухайн бизнес эрхлэгч, бизнесийн үйл ажиллагааны бодитой сэргэлт, бодитой мөнгөн урсгалтай нь уялдуулж төсвийн өрийг барагдуулах чиглэлээр арга хэмжээг авч ажиллаж байгаа.

2024 онд төсвийн орлогын төлөвлөгөө дээр татварын өр төлбөрийг барагдуулахтай холбоотой тодорхой мөнгөн дүнгээр төсвийн хуульд туссан байгаа. Үүнтэй холбоотой бид хуулийн барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллана гэдгийг хэлье.

Гуравт, татварын албадан гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг сайжруулах, хоорондын уялдааг сайжруулах замаар үр дүнтэй аргыг хэрэгжүүлж ажилла гэсэн ийм зөвлөмж өгсөн.

Энэ чиглэлээр бид холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаануудыг илүү сайжруулах, мэдээлэл харилцан солилцох ажлаа илүү бодит цагийн горимд шилжүүлэх чиглэлээр хамтран ажиллагаагаа эхлүүлээд явж байгаа гэдгийг хэлье.

Дөрөвт, татварын үйл ажиллагааг техник, мэдээллийн дэвшилттэй технологитой уялдуулан бодит цагийн горимоор оновчтой зохион байгуулж, дэвшилтэт технологийг төрийн бусад байгууллагуудад таниулж, мэдээлэл солилцох гэсэн зөвлөмж өгсөн.

Энэ чиглэлээр бид агентлагийн дарга нарын хурал дээр би татварын албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хийсэн. Холбогдох төрийн байгууллагууд манай татварын албаны цахимжилттай холбоотой танилцах хүсэлт ирдэг.

Түүнтэй холбоотой бид хүлээж авч энэ мэдээллийг өгч хамтарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Эцэст нь, төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалахтай холбоотой хуулийг анхаарч ажилла гэсэн ийм зөвлөмж өгсөн.

Үүний дагуу Тагнуулын ерөнхий газарт хүсэлт тавиад Тагнуулын ерөнхий газраас манай дээр шалгалтын баг ирж ажилласан.

Шалгалтын багийн дагуу манайд бас 5 зөвлөмж өгсөн. Тэр зөвлөмжийг бид хэрэгжүүлээд ажиллаж байна гэсэн ийм аудитын байгууллагаас татварын байгууллагад өгсөн 5 зөвлөмжийг ингэж хэрэгжүүлж ажиллаж байна гэдэг ийм товч мэдээлэл өгье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: С.Ганбаатар гишүүн нэмж тодруулъя. Шаардлагатай бол хоёр удаа тодруулж болно.

С.Ганбаатар гишүүний микрофон.

С.Ганбаатар: Энэ татварын хамт олонд хэлэхэд ер нь Татварын дарга юм уу, эсвэл Ерөнхий сайд, хэн нэгэн сайдыг ард түмэн сонгодоггүй.

Улсын Их Хурлын гишүүдийг ард түмэн сонгоод, харин бид та нараар ажил хийлгэдэг.

Тэгэхээр бидний төлөөний, та нарыг хянах ёстой байгууллага нь аудит. Өөдөөс англи нэр томъёо хэлээд байна. Би түүнд шүүмжлэлтэй л хандаж байна. Зүгээр хэлмээр. Цаг хэмнэе.

Таны саяын 5 зөвлөмж дотор ийм юм орсонгүй.

Тодруулж асууж байгаа юм. Энэ хуудас 20 дээр байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас орон нутагт хуваарилах орлогыг **705.3** тэрбум төгрөгөөр төлөвлөсөн. Энэ чинь хууль шүү дээ. Энэ чинь төлөвлөж өгөх ёстой.

Гүйцэтгэлээр **443.1** тэрбум төгрөгөөр хуваарилчхаад **262.0** тэрбум төгрөгийг дутуу олгосон байна. Энэ чинь цаана нь яг орон нутгийн нийт ард иргэд л хохирч байгаа шүү дээ.

Яагаад энэ **262.2** тэрбум төгрөгийг хуваарилалтаас өгсөнгүй вэ гэдэг дээр надад хариулт хэлэх болов уу гэж би бодож байсан.

3.2.3. Сангийн яамнаас тайлант оны санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан аймгуудад, одоо яг энэ дээр дутагдсан аймгуудад 2023 онд хуваарилах орлогоос

133.4 тэрбум төгрөг урьдчилан олгосон байна.

Дархан-Уул, Өмнөговь, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хуваарилах орлогыг 7.4 буюу 16.7 хувиар олгосон байна. Энэ дээр надад хариулт хэлж өгөөч ээ.

Энэ татвартай холбоотой учраас би асууж байгаа юм шүү. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой учраас.

3.2.3, 3.2.2, 20 дугаар хуудас.

Г.Тэмүүлэн: С.Ганбаатар гишүүн аудитын гаргасан дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж байна.

Энэ дээр Сангийн яам хариулах уу? Татварын ерөнхий газар хариулах уу? Гараа өргөөрэй.

Б.Заяабал дарга уу? 7 номер.

Б.Заяабал: Энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 60, 40-өөр, орон нутагт 40 хувийг, 60 хувийг нь улсын төсөвт авдаг хуулийн үйлчлэл 2022 оны 01 сарын 01-нээс эхэлж хэрэгжиж байгаа.

Хэрэгжиж эхэлсэн эхний жил төсвийн аудитын хяналтад хамрагдах он, цаг хугацаанд ороод тавигдсан байгаа.

40 хувийн хуваарилалтаар **705.0** тэрбум төгрөгийн орлогыг, өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь болох **705.0** тэрбум төгрөг орон нутагт очно гэдэг хуваарилалтыг хийсэн.

Тэгэхдээ энэ орлогыг яаж хуваарилах вэ гэдэг нь уг хуулийн дагуу,

Сангийн сайдын баталсан журмын дагуу хуваарилагддаг.

Нэгдүгээрт, энэ дээр тухайн аж ахуйн нэгжийн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны орлого дээр нь төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь нь тухайн орон нутагтаа очих ёстой.

Тэгэхээр энэ орон нутгийн төсвийн орлогын 40 хувийн хуваарилалт нь 262.0 тэрбум төгрөгөөр бага байгаа гэдэг нь тухайн орон нутагт төлөвлөж байсан аж ахуйн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны орлого нь 40 хувиас бага байсан гэсэн. 40 хувь нь төлөвлөж байсан 705.0 тэрбум төгрөгөөс бага орлого орсон гэсэн үг.

Нийтдээ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэдэг төрлийнхөө хувьд манай төсвийн орлого төлөвлөж байснаасаа давж биелсэн.

Гэхдээ тухайн орон нутагтаа очих ёстой, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үндсэн үйл ажиллагааны орлогын 40 хувьд нь очих ёстой орлого нь зарим аймгууд дээр хүрээгүй, зарим аймгууд дээр илүү гарсан.

Тэгээд хуваарилагдсан дүнгээс илүү гарсан нь улсын төсөвтөө хуваарилагдаад явж байгаа гэдгийг хэлье. 3.2.2-той холбоотойгоор.

Мөн 3.2.3 дээр чинь юу юм байна. Сангийн яамнаас олгосон тайлангийн. Үүнийг би яг сайн тайлбарлаж мэдэхгүй юм байна.

Г.Тэмүүлэн: Аудитын тайлангийн дүгнэлтийн 3.2.3 дээр тайлбар өгөх албан тушаалтан байна уу?

Сангийн яам. Албан тушаал, овог нэрээ танилцуулаад хариултад товч бөгөөд тодорхой хариулаарай.

Б.Энхбат: Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхбат. Гишүүний асуултад хариулья.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг хуваарилдаг журам дээр яах вэ аудитын зөвлөмж дээр илүү давсан орлогыг хуваарилахгүй байна гэсэн тийм асуудал тусгасан байна лээ.

Энэ асуудлаар төслөө боловсруулаад батлуулахаар ажиллаж байгаа.

Зөвлөмжийн дагуу төслөө боловсруулаад энэ ондоо багтааж батлуулахаар ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Аудитын тайлан.

Энэ тайлан баталгаажуулах тухай юун дээр татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, үр дүн, нөлөө сэдэвт гээд тайлан орж ирж байгаа юм.

Тэгэхээр татварын шинэчлэл яваад байна гэж ойлгоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр Их Хурлаас ахиад татварын шинэчлэлтэй холбоотой ажлын хэсгүүд гараад байгаа. Тэгээд үүнийг юу гэж ойлгох вэ?

Шинэчлэлийг ахиж шинэчлэх гээд байгаа юм уу, тогтолцоог нь өөрчлөх гээд

байгаа юм уу? Шинэчлэлийг шинэчилнэ гэхээрээ ямар реформ болох гээд байгаа юм бэ гэдэг дээр нэг ойлгомжтой юм авъя. Асуулт асууж байна.

Хоёрт нь, энэ юуг хариулахгүй байна л даа.

3 дугаар бүлгийн 3.2.2, 3.2.3 дээр төлөвлөсөн орлогыг нь өгөхгүй байгаа юм. Давсан орлогыг нь. Тэгээд энэ бусад юунууд болохоор хуваарилаад байгаа байхгүй юу. Энэ ингэхээр арай шударга бус үйлдэл гарсан байгаа юм.

Тэгээд үүнийг залруул гээд энэ юун дээр хэлчихсэн юм шиг санагдаад байгаа юм. Энэ хардаа. Аудитаар тогтоосон акт, өгсөн шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахыг Я.Самбуунямд даалгасугай гэж.

Тэгэхээр энэ давсан орлогыг нь өгөөгүй хэсгийг орон нутагт нь олгуулна гэсэн үг үү? Жишээлэх юм бол энэ дээр ийм байна шүү дээ.

Дорноговь аймгаас 5.4 тэрбум төгрөг, Сүхбаатар аймгаас 6.2 тэрбум төгрөг, Ховд аймгаас 6.2 тэрбум төгрөг. Давсан орлогыг нь өгөөгүй.

Тэгсэн мөртөө даваагүй газруудад нь хуваарилаад өгчихсэн байгаа юм. 2023 оноос урьдчилж өгнө гэхээр яаж урьдчилж өгдөг юм.

Тэгэхээр 2023 оны төсөв дээр яаж батлагдсан гэсэн үг вэ? Маш тодорхой тайлбар авах хэрэгтэй байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг яг энэ гүйцэтгэлээр нь өгч байх ёстой.

Яагаад вэ гэхээр Монгол Улсын татвар чинь өөрөө шударга бус байгаа шүү дээ. Жишээлэх юм бол Хөвсгөл аймаг, Архангай аймаг бид аялал жуулчлалын бүс нутаг, эко аймаг гээд байдаг. Тэгээд ерөөсөө төсөвт мөнгө төвлөрүүлдэггүй. Тэгсэн мөртөө бусад газруудын муу хэлэгдээд байгаа уул уурхайтай Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар гэдэг юм уу энэ аймгуудын мөнгөнөөс хангалттай хэмжээгээр авдаг.

Энэ асуудлыг ер нь одоо энэ татварын шинэчлэл, дараагийн реформ дээр ер нь яаж тусгая гэж бодож байдаг юм бэ?

Дараагийн нэг асуудал бол энэ хүн амын орлогын албан татварыг орон нутагт нэмэгдүүлж байна, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын юмыг орон нутагт нэмэгдүүлж байна гэнгүүтээ зөрүүлээд төсвийн дэмжлэгийг нь хасчихдаг. Ямар ч ялгаа байдаггүй. Нэмэгдэхүүний байрыг өөрчлөхөд нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй гэдэг зарчим яваад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ гурван асуудал дээр тодорхой хариулт аваад тэгээд тодруулъя гэж бодож байна.

3 дугаар бүлгийн 3.2.3-ыг ерөөсөө тайлбарлахгүй байна шүү дээ. Яагаад гээд.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Эхлээд 2 номер. Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням дарга хариулаад дараа нь Сангийн яам,

Татварын ерөнхий газар нэмэлт хариулт өгөөрэй.

Я.Самбууням: Ж.Батсуурь гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Я.Самбууням.

Манай аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хэрэгжүүлэх хугацаа 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр байгаа.

Тэгэхээр одоогоор бид нарт аудитаар өгсөн дүн, дүгнэлттэй холбогдуулсан хэрэгжилт ирээгүй байгаа.

Хоёрдугаарт нь, бидний аудитаар илрүүлсэн 3.2.2, 3.2.3-т заагдсан асуудал 2022 онд буюу 2023 оны хуваарилагдах орлогыг урьдчилаад өгчихсөн байгаа нь буруу байна.

Энд юу гэхээр 2022 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас төсөвт хуримтлагдсанаас нь 40 хувийг нь буцааж олгох ёстой. 2023 оныхыг хуваарилах ёсгүй. Үүнийг урьдчилаад хуваарилчихсан нь буруу байна гэдгийг л аудитаар илрүүлэлт болгож гаргаж ирсэн байгаа юм.

Урьдчилаад өгчихсөн орлого нь 2023 оны төсвийн төсөл дээр энэ нь суугдаад дутуу тусгагдахаар орчихсон байсан. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Шинэчлэлтэй холбоотой асуудлаар шинэчлэлийн агуулга, зорилго. Хэн хариулах вэ. Гараа өгөөрэй.

Сангийн яам, Татварын ерөнхий газар. Хариулах хүн байна уу?

Татварын шинэчлэлийн агуулга, зорилго болоод 2019 оны шинэчлэлийн талаар асуугаад байгаа юм.

2019 оны татварын шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор ер нь ямар агуулгын хүрээнд энэ шинэчлэл хийгдсэн юм. Зорилго нь юу байсан юм гэж асуусан.

Ж.Батсуурь гишүүн нэмж тодруулчихъя. Дахиад.

Ж.Батсуурь: 2019 онд татварын шинэчлэл хийсэн шинэчлэлтэй холбоотой гээд тайлан ирээд байгаа байхгүй юу.

Гэтэл ахиад шинэчлэлтэй холбоотой ажлын хэсгүүд гараад яваад байгааг юу гэж ойлгох юм бэ? Ямар юм хийх гээд байгаа юм?

Одоо жишээ нь үдээс хойш татвартай холбоотой ажлын хэсгүүд гараад хуралдаад байна шүү дээ. Энэ ямар шинэчлэл хийх гээд хуралдаад байгаа юм бэ гэсэн асуудал асуугаад байна.

Тэгэхээр энд Их Хурал, Засгийн газрын хоёр чинь хоёр өөр юм яриад яваад байна уу гэсэн асуудлыг яриад байгаа юм л даа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Би таныг 2019 оны юутай холбоотой гэж ойлгосон.

Нэгд, яах вэ Татварын эрх зүйн орчин дээр дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан.

Дээрээс нь иргэдээс гаргасан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болоод нийгмийн даатгалын шимтгэл, нэмэгдсэн өртгийн албан татварын

буцаан олголттой холбоотойгоор иргэдээс гаргасан санал болоод 100 мянган саналын хүрээнд энэ асуудлыг судлах, татварын өнөөгийн тогтолцоо болоод эрх зүйн орчин, татварын ачаалал дээр дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан.

Тэгэхээр энэ дээр Их Хурал болоод Байнгын хорооны зүгээс өнөөгийн татварын орчин дээр дүн шинжилгээ хийх юм.

Өнөөдрийн орж ирсэн аудитын тайлан бол 2019 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн татварын шинэчлэл дээр гүйцэтгэлийн аудитын тайлан гүйцэтгэсэн зүйл байгаа юм.

Ж.Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Я.Самбууням, Б.Заяабал та хоёр хоёулаа хариулаадхаач.

Энэ тайлан дээр тусгагдсан алдааг засна гээд байна.

Тэгэхээр энэ олгогдоогүй байгаа зүйлийг 2024 онд нөхөн олгоно гэсэн үг үү? Тодорхой хариулаад өгөөч.

3 дугаар бүлгийн 3.2.3. Дорноговь -5.4, Сүхбаатар -6.2, Ховд 6.2, Орхон 3.7.

Үүнийг тэгээд нэгэнт аудитын дүгнэлт гарч байгаа бол 2024 он дээр нөхөж өгөх үү?

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүний асуултад хариулъя. Б.Заяабал дарга уу? 7 номер.

Б.Заяабал: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд буурсан өөрчлөлтөөр 60, 40-өөр орон нутаг, улсын төсөвт хуваарилдаг хуулийн

өөрчлөлт 2022 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж байгаа гэдгийг би хэлсэн.

Энэ дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварт орсон өөрчлөлтийн дагуу 2022 онд А7 Сангийн сайдын тушаалаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам батлагдсан.

Энэ журмаар саяын тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг орон нутагт нь хуваарилна.

Тэгэхдээ энэ нь төлөвлөгөөт хэмжээ буюу аж ахуйн нэгжийн орлогынхоо 40 хувьдаа байх ёстой.

Хэрвээ илүү давах юм бол илүү давсан аймгуудын орлого улсын төсөвтөө хуваарилагдана гэдэг ийм байдлаар журамд тусгагдсан.

Энэ нь 2022 онд хэрэгжсэн журам байгаа.

Сая Сангийн яамны төлөөллийн ярьснаар аудитын журмын дагуу Сангийн сайдын баталсан журамд эргэж өөрчлөлт хийх асуудлыг төлөвлөж байгаа гэсэн хариулт өгсөн.

Тэгэхээр журамд өөрчлөлт орсны дараа энэ нь хэрэгжээд явна гэж ойлгож байна.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батсуурь: Асуувал зөндөө л юмнууд байна л даа.

Тэгээд би одоо тойрогтой холбоотой.

Үндэсний аудитын газар ер нь хууль барьж аудит хийх юм уу, журам барьж аудит хийх юм уу? Энэ дээр яг тодорхой хэлж өгөөч.

Хууль нь том юм уу, журам нь том юм уу?

Журам нь өөрчлөгдчихвөл хуулиа дагая гэх л хариулт би сонсоод байх юм.

Тэгвэл хууль байхын хэрэг байгаа юм уу? Хуульчлахын хэрэг байгаа юм уу?

40 хувиа л авъя гээд байгаа байхгүй юу. 40 хувиас давсныг нь авахыг нь хүлээн зөвшөөрч байна. 40 хувиа.

Тэгэхээр **“төлөвлөгөөнөөс давсныг нь улсын төсөвт авна”** гэсэн ямар ч үг, үсэг байхгүй.

40 хувиас давсныг нь өгөхийг нь ойлгож байгаа байхгүй юу. Тэгээд хууль давсан журам байж болдог юм уу? Үүнийг аудит.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Аудит асуултад хариулъя. 3 номер Ц.Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Ж.Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудитыг хийхдээ нийцлийн аудиттай хослуулан хийдэг болсон.

Энэ нь хуульд хэрхэн нийцэж байна вэ гэдэг асуудлыг бас давхар үздэг ийм Монгол Улсын Ерөнхий аудитораар

бүтэц, зохион байгуулалт хийгдээд жил гаруй болж байна.

Бид энэ Төсвийн тухай хуультай Сангийн сайдын 47 дугаар журмыг нийцэхгүй байна гэж энэ тайланд дүгнэсэн байгаа.

Тийм учраас Сангийн яаманд төсвийн бодлогыг татварын бодлоготой уялдуулан төлөвлөх, татварын орлогыг улсын болон орон нутгийн төсөвт хуваарилах талаар холбогдох хуульд нийцүүлэн журамдаа өөрчлөлт оруулах зөвлөмжийг хүргүүлсэн байгаа.

Сангийн яам энэ зөвлөмжийг аваад энэ журамдаа өөрчлөлт оруулаад журам нь батлагдах түвшинд явж байгаа.

Тийм учраас 2023 оны төсвөөс эхлээд Төсвийн тухай хуульд заасан 60, 40-ийн хуваарилалтын асуудал хуулийн дагуу явна гэж ингэж ойлгож байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Би нэмээд тодруулаад асуугаадахъя. Та хоёр удаа асуусан байгаа.

Би таныг буруу тоолоогүй бол хоёр асуулаа гэж бодсон. Ойлголоо. Нэг нэмээд тодруулчихъя.

Минутдаа багтаагаарай.
Ж.Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: 2023 оноос энэ алдаа засагдах юм байна.

Тэгэхээр 2022 оны алдааг энэ 4-т нь заачихсан байна шүү дээ. Аудитаар тогтоосон акт өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд тавьж үр дүнг ажиллахыг Я.Самбуунямд даалгасугай гэж байна.

Тэгэхээр нэгэнт алдаа гарчихсан юм болохоор 2022 оны энэ алдаанаас гарсан энэ зөрүүг олгох уу л гэж асуугаад байна л даа.

2023 оноос Та бүхэн засах юм байна. 2022 оны тэр хуулийн зөрчлийг арилгаад алдааг зас гээд Я.Самбуунямд өөрөө өгчихсөн байна.

Тэгэхээр алдааг засна гэдэг чинь өгөөгүй мөнгийг нь өгнө өө л гэсэн үг биз дээ. Үүнийг өгөх үү? Яаж өгөх вэ гэсэн санал дээр тодорхой хариулт өгөх ёстой шүү дээ.

Г.Тэмүүлэн: Ц.Наранчимэг дарга 3 номер.

Ц.Наранчимэг: Монгол Улсын ерөнхий аудиторын баталгаажуулсан тайлангаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавихыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газарт үүрэг болгосон.

Тэгэхээр Төсвийн тухай хуульд орсон шинэчлэлээр Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд 30 хоногийн дотор төлөвлөгөө гаргаж ирүүлэх ийм хуулийн зохицуулалтыг оруулсан.

Хэрвээ хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцох зохицуулалттай байна.

Тэгэхээр 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгасан талаарх тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээд түүн дээр нь Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар дахиж хяналт хэрэгжүүлээд, хэрэгжүүлээгүй байх юм бол хариуцлага тооцно гэсэн

тушаалын 4 дэх заалт ийм зохицуулалттай заалт байгаа.

Г.Тэмүүлэн: Би уг нь нэр оруулсан байсан. Албан ёсоор минут нь гүйгээгүй байна. Би нэг асуулт асуугаадахъя.

Ямар ч бай Аудитын ерөнхий газраас гүйцэтгэлийн аудитууд гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэж байгаа.

7, 8 сэдвээр аудит гүйцэтгээд тайлангуудаа ирүүлсэн.

Төсвийн Байнгын хорооноос ямар ч бай эхний 2 аудитын тайланг оруулж байна.

Ингээд 12 сардаа багтаагаад үлдсэн 5 аудитын тайланг салбар салбараар нь бид сегментлээд оруулахаар төлөвлөж байгаа.

Ямар ч бай Үндэсний аудитын газраас аудитын гүйцэтгэлийн тайланг их үр дүнтэй хэрэгжүүлж байна гэж Байнгын хороон даргын хувьд үзэж байгаа.

Би үүнтэй холбогдуулаад хоёр, гурван асуултуудыг асууя. Та бүхний гаргасан тайлантай холбогдуулаад.

Сая Ж.Батсуурь гишүүн асуугаад байгаа. Энэ 3.2, 3.2.3 гэдгийг нь дүгнэлттэй холбогдуулаад би тодруулж Аудитын газраас эхлээд асуугаадахъя.

Тэгэхээр 3.2.3 дээр Сангийн яамнаас тайлант оны санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан аймгуудад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2023 онд хуваарилах орлогоос 133.4 тэрбум төгрөгийг урьдчилан олгосон байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Тэгэхээр энэ өөрөө яг юу гэсэн үг юм? Би одоо жишээ нь “**тайлант оны санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан**” гэдэг чинь тайлант он 2022 оныг хэлж байна гэсэн үг.

2022 он дутагдсан эх үүсвэрийг 2023 онд хуваарилах орлогоос урьдчилж олгосон байна гэсэн үг болж байгаа юм уу?

Тэгэхээр яг ямар хууль, эрх зүйн үндэслэлийн хүрээнд үүнийг олгосон гэж Аудитын газраас дүгнэж байгаа юм бэ?

Та бүхний үзэж байгааг сая Ж.Батсуурь гишүүний асуусан асуулттай холбогдуулаад дүгнээд үзэхээр журмын хүрээнд санхүүжилтийг урьдчилж олгосон байна. Тэр журам нь хуулиас давсан юм байна.

Тэгэхээр магадгүй Төсвийн хууль болоод 2022 оны төсвийн тухай хуулиас өөрөөр юу гэдэг юм хуваарилсан байна гэсэн ийм дүгнэлт гэсэн үг юм уу?

Энэ дээр эхлээд аудит. Та нар яг хариуцлагатай хариулаач.

Хэрэв үнэхээр тийм байвал хууль тогтоомжоос давсан тийм шийдвэр гаргаж болж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуудал байгаа юм.

Ц.Наранчимэг дарга. 2 номер.

Я.Самбууням: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Я.Самбууням.

Бидний тайлангийн 3.2.1-д энэ Сангийн сайдын 2022 онд баталсан А7 тушаал Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн

төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт хэрэгжүүлэх журам нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан.

Энэ асуудлыг бид 2022 оны Засгийн газрын нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайландаа мөн тусгасан. Энэ тайлан дээр орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх, дутагдсан эх үүсвэрийг 2023 оны татварын орлогоос урьдчилж төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан.

Уг нь тухайн 2022 ондоо төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогоос нь 40 хувь болон түүнээс дээшээ давсан орлогыг л хуваарилах ёстой. 2023 оны орлогыг урьдчилж нөхөж олгох бололцоогүй гэдэг. Энэ хууль зөрчигдсөн байна, нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр хуульд нийцэхгүй журам батлуулчихсан. Түүнийхээ хүрээнд санхүүжилтийг урьдчилж олгосон гэсэн үг болж байна уу, 2022 онд.

Я.Самбууням: Тийм. Хуульд нийцэхгүй байна гээд журамдаа өөрчлөлт оруулах зөвлөмжийг Засгийн газрын нэгдсэн тайлангаар болон манай татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө аудитаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлсэн. Энэ хүрээнд А7 баталсан журамдаа өөрчлөлт оруулахаар Сангийн яам ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Тэгвэл би нэмээд тодруулаад асуугаадахъя.

Тэгэхээр Сангийн яаманд Аудитын газраас яг саяын 3.2.3-тай холбогдуулаад орон нутагт хуваарилах талаарх холбогдох хуульд нийцүүлэн журамд өөрчлөлт оруулж мөрдөж ажиллах гэсэн зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлж байгаа юм байна. Тийм ээ.

Б.Жавхлан сайдаас би нэмээд тодруулаадахъя.

Тэгэхээр Сангийн сайдын 2022 оны А7 дугаар тушаал буюу түүгээр 40 хувийг орон нутагт хуваарилахаар гээд заачихсан юм байна.

Тэгэхээр журам нь хуулиас давсан бол нэгд журмаа өөрчлөх ёстой асуудал болох нь.

Хоёрт, хэрэв журам дээр хэрэгжих боломжгүй хувь хэмжээ тогтоочихсон бол бид тэрийг бууруулах гэдэг юм уу, тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулах л зайлшгүй шаардлага гарах гээд байх шиг байгаа юм.

Дээрээс нь би дахиад нэмж тодруулах гээд байгаа нь магадгүй, эсвэл орлого дутагдсан аймгууд гэж байгаа нь эхнээсээ орлогыг төлөвлөхдөө төлөвлөлт дээр нь Сангийн яам болоод Татварын ерөнхий газар алдаа гаргасан юм уу гэдэг асуудал болчихоод байгаа юм.

Тэгэхээр хэт өндрөөр төлөвлөдөг. Эргээд журамдаа нийцдэггүй. Дахиад нөгөөдөхөө хуваарилж чаддаггүй. Тэгээд хууль давсан гадуур урьдчилгаа төлбөрийг өгөхөөс аргагүй болдог.

Ингээд тухайн орон нутаг санхүүжилтийн эх үүсвэр нь дутагдах л ийм эрсдэлд оруулаад байгаа юм уу гэсэн би тийм логикийг л хараад байна л даа.

Тэгэхээр төлөвлөлт дээр 70-тай байсан юм уу? Хоёр дахь журамтай холбоотой асуудлууд дээрээ Сангийн яам ямар бодлого баримтлах гэж байгаа юм гэдэг асуудал дээр тайлбар өгөөч.

Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Сангийн яамны хувьд сүүлийн жилүүдэд энэ аудитынхантайгаа их ойрхон хамтарч хичээж ажиллаж байгаа.

Төсвийн реформууд тодорхой хэмжээнд сайн явж үр дүнгээ өгч байгаа.

2019 оны татварын реформ, татварын хуулийн өөрчлөлт шинэ зохицуулалт маш сайн үр дүнгээ өгч байгаа.

Тэр нь юунаас харагдаж байна вэ гэхээр бид 2020 оноос хойш татварын орлого, төсвийн орлого бүрдүүлэлт хоёр дахин нэмэгдсэн. Хоёр дахин нэмэгдэж, өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүн хойтон 74 их наяд хүрэх гэж байна.

Өөрөөр хэлбэл бид 2019 оны хуулиас хойш архи, согтууруулах ундаанаас өөр ямар ч татварын хувь хэмжээг өөрчлөөгүй.

Өөрөөр хэлбэл татварын шинэчлэлийн үр дүнд татварын суурь маш сайн тэлсэн. Ингээд орлого бүрдүүлэлт, төвлөрөлт сайжирсан, татварын орчин ил тод болсон, цахимжсан, нэлээн либерал болж ирсэн. Ингээд маш сайн үр дүнгээ өгч байгаа юм. Энэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр 40 хувь яриад байгаа юм. Ер нь энэ бол шинэ хууль.

Энэ бол татварын бодлого гэхээсээ илүү орон нутгийн хөгжлийн бодлогыг бид татварын биш өөр хуулиар зохицуулсан зохицуулалт шүү дээ.

Энэ дээр яах вэ, төлөвлөлтөд бидний хувьд нэлээн шинэ зүйл байгаа юм.

Ер нь аймаг болгон өөр өөрсдийнхөө онцлогоос хамаараад, ялангуяа тухайн орон нутагт байгаа уул уурхайгаас нь хамаараад энэ 40 хувийн орлого бүрдүүлэлт тасрах эрсдэл их өндөр юм билээ.

Хамгийн ойрхон жишээ гэвэл жишээ нь Дархан байна.

Дархан нэлээн том төлөвлөлттэй явж байгаад Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн экспортоос шалтгаалаад 2022 онд орлого нь тасарсан. Энэ жил арай гэж ер нь хүрэх шинжтэй байна.

Нийтээрээ төсвийн орлого бүрдүүлэлт сайн явж байгаа. Давж биелээд явж байгаа. Тэр дээр төлөвлөлт дээр асуудал байхгүй гэж бодож байна.

Ж.Батсуурь гишүүн их сайн санаж байгаа байх. Сүхбаатарт нэг удаа яалаа. Тийм ээ. Орон нутгийн нөгөө юуны орлогыг өндөр төлөвлөөд тухайн жилдээ орлого нь тасраад бүр балраагүй юу. Тэр чинь хэдэн онд билээ.

Шэх мэтчилэн ийм эрсдэлүүд ер нь гарах их өндөр эрсдэлтэй юм билээ.

Тэгэхдээ аль болох бид эндээс ухрахгүй. Орон нутгийн хөгжил, өөрөө өөрийгөө аваад явах тэр эдийн засгийн гол хөшүүрэг нь энэ их зөв зохицуулалт болчих болов уу гэж хараад цааш нь явуулах гээд байгаа юм.

Тэгээд тэр ямар юмных нь хууль зөрчих вэ дээ. Тэр аудитынх нь жоохон дутуу тайлбарлаад байх юм.

Хууль дээр нь гүйцэд зохицуулалт байхгүй байгаа байхгүй юу. Өгнө ч гэсэн юм байхгүй, өгөхгүй ч гэсэн юм байхгүй.

Тэгэхээр нэгэнт зохицуулаагүй байгаа ийм зүйл дээр бид журамлаж нарийн шинэ зохицуулалт хийгээд тэгээд түүгээрээ явъя л гэж байгаа юм. Өгсөн ч болно, өгөхгүй ч байж болно.

Бид төсвийн хууль чинь аймаг болгоноор гардаггүй. Улсын нэгдсэн төсөв гэж хуулийн зохицуулалт байдаг. 40 хувийг нь тэнд хуваарилна л гэж байгаа.

Тийм учраас бас яг шийдчихсэн ч юм байхгүй. Давсныг нь өгнө гээд шийдчихсэн юм бас байхгүй байгаа шүү.

Бид журам дээр яг ажиллаж байна. 40 хувь бол байгаа. 40 хувь нь хуульчилчихсан. Давсных гэдгийг хуульчлаагүй байгаа.

Харин та бол өмнөхөө нөхөж өгөх үү гээд байгаа шүү дээ. Дотаци нэмж өгөх үү гээд байна уу, эсвэл давсныхыг нь буцааж авах гээд байгаа юм уу.

Тэгвэл наадахыг чинь өгч байгаа шүү дээ. Үгүй ээ, үгүй. Өгч байгаа. Өгөлгүй яадаг юм. Наадах чинь дутуу байвал л очихгүй байгаа болохоос биш. Гүйцэд орлого нь орчихсон үед автомат наадах чинь бүр явж байгаа. Тэнд ямар нэгэн тийм хүний оролцоо байхгүй. Тэгж тооцогдоод явдаг.

Хоёр дахь нь юу гэлээ? Үгүй ээ, үгүй. Тийм юм байхгүй. Наадах чинь

хэрвээ 40 хувийн төлөвлөгөөнд орсон л наадах чинь биелж явж байгаа.

Г.Тэмүүлэн: Хоёр зүйл байна. Нэг нь илүү өгчихсөн, нэг нь дутуу өгчихсөн гэсэн л хоёр зүйл.

Тэгэхээр 3.2.3 чинь яг л тодорхой асуудал байгаа байхгүй юу. Хоёр асуудал болчихоод байгаа юм.

Нэг нь дутуу өгсөн. Нөгөөх нь илүү өгсөн. Аль аль нь нэг талдаа тухайн жилийн төсвийн хууль болоод том төсвийнхөө хуультайгаа зөрчилтэй. Ингээд үүнийг зохицуулж байгаа асуудал нь Сангийн сайдын журмын хүрээнд хийгдэж байгаа. Журам нь магадгүй түүн дээрээ 40 хувиа заачихсан.

Тэгэхээр тэрийг бид магадгүй эхнийхээ орлого төлөвлөлт дээрээ алдаа гаргасан байж магадгүй. Хэрэв 40 хувиар нь өгөх гэхээр зөрчил үүсдэг ийм асуудлууд байгаа юм. Орлогын төлөвлөлттэй холбоотой.

Би энд харж байгаа өнцөг бол орлогын төлөвлөлттэй холбоотой хийдэл гараад байна уу гэж хараад байгаа байхгүй юу. Аудит ч гэсэн ерөнхийдөө энэ дээр байр суурь нэг байна уу гэж хараад байгаа юм.

Үүнийг тодруулж өгөөч.

Хоёр дахь нь, би зүгээр нэг зүйлийг хэлээдэхье.

Ж.Батсуурь гишүүн яриад байна.

Татварын ачааллыг салбар сегмент тус бүрээр ер нь тооцож байх ёстой. Энэ дээр Татварын ерөнхий газар хуульд заасан хугацааны дагуу ажиллахгүй байгаад байна. Энэ дээрээ юу хийх гээд

байгаа юм бэ. Нэг талдаа татвар эдийн засгийн жигд өсөлтөд дэмжлэг үзүүлэх, тогтворжуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа юм уу гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуулиараа аудитын дүгнэлтдээ ч зааснаар 51.3 дээр тухайн тэр юу гэдэг юм хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутам үнэлгээ хийнэ гэсэн асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн 2019 онд хэрэгжүүлсэн татварын шинэчлэлийн асуудал маань одоо 2024 он гарах гэж байна. Бараг 5 дахь жилдээ нүүрлэж байна. Татварын ерөнхий газраас ер нь яг 2019 онд хэрэгжүүлсэн татварын шинэчлэлтэй холбогдуулаад дүн шинжилгээ хийж байгаа зүйл байгаа юу?

Одоо бид нар яг энэ дээр бас нэг тодорхой бодитоор нь анхаарч үзэх шаардлага байгаа байх гэж харж байгаа.

Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Б.Заяабал дарга өгөх үү, хэн өгөх вэ? Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Татварын ерөнхий газрууд манай гүйцэтгэгч агентлаг. Тэгээд эдний дээр ямар нэг дүн шинжилгээ, бодлогын асуудал огт яригддаггүй. Гаргасан татварын хууль, журмын дагуу татварын орлого бүрдүүлэлт дээрээ ажилладаг ийм байгууллага.

Сангийн яамны хувьд мэдээж байнга энэ дээр дүн шинжилгээ, татварын асуудлууд, бодлогууд дээр бодлогоо зангидаад явалгүй яах вэ.

Тэгээд ер нь 2019 оны татварын шинэчлэлийн асуудал одоо 5 жилийн дараа эргээд харахад үр дүнгээ маш сайн өгч байгаа. Маш сайн өгч байгаа.

Ер нь татварын орчин өөрөө их ойлгомжтой, ил тод, хамгийн гол нь тогтвортой байх нь их чухал. Бодлого өөрөө. Тогтвортой байна гэдэг маань цаг хугацааны л асуудал. 4 жил, 8 жил ядаж.

Тийм учраас би түрүүн хоёртоо хэлсэн. 2019 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүн хоёр дахин нэмэгдсэн. Татварын орлого бүрдүүлэлт хоёр дахин нэмэгдсэн.

Харин татварын хувь хэмжээнд огт өөрчлөлт ороогүй. Зөвхөн архи, согтууруулах ундааны онцгой татвар дээр л өөрчлөлт орсон. Өөр ямар ч татварын өөрчлөлт ороогүй гэж байхад суурь тэлээд татварын орлого ингэж сайн нэмэгдэж, татварын ил тод байдал, далд эдийн засаг тодорхой хэмжээнд сайн нэмэгдэж, үр дүнгээ өгч байгаа нь 2019 оны татварын шинэчлэл ямар хэмжээнд явсан нь энэ үр дүнгээр харагдаж байгаа юм. Тийм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Сая аудит зөвлөмж алдаа, зөрчил, дутагдалтай холбогдуулаад дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн. Холбогдох байгууллагуудад.

Тэгэхээр аудитын албан шаардлагын хэрэгжилт нь хугацаандаа ирсэн үү? Та бүхнийг хүргүүлснээс хойш. Хуульд заасан хугацаанд.

Тодорхой үүсэж байгаа нөхцөл байдлууд, алдаа зөрчил байгаа бол энэ дээр хуулийн ямар хариуцлага тооцох ёстой юм? Энэ дээр нэг тодорхой тайлбар өгөөч.

3 номер Ц.Наранчимэг дарга.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Ц.Наранчимэг байна.

Аудитын тайланг хүргэгдсэнээс хойш Сангийн яам болон холбогдох газрууд хугацаанд нь аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг гаргах төлөвлөгөөгөө хүргүүлж ажиллаж байгаа.

Энэ төлөвлөгөөг хүргүүлж байгаагийн нэг ажлынх нь үр дүн бол энэ журамд оруулахаар ажиллаж байгаа нь цаг хугацаандаа аудитаас өгч байгаа зөвлөмж, асуудлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гаргаад, аудитын байгууллагатай бас хамтраад энэ дээр ямар асуудал байгаа дээр хамтарч ажиллах вэ гэдэг энэ ажлыг бас хариуцлагатай сайн хэрэгжүүлж байгаа гэж ингэж ойлгож болно.

Бид яг бодит хэрэгжилтийг тайланд заасны дагуу 2024 оны 10 сарын 01-нд дахин аудит хийдэг.

Энэ аудитаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дээрээ дахин аудит хяналт хэрэгжүүлж, эцсийн дүгнэлтийг гаргадаг.

Түүгээр хэрвээ хэрэгжүүлээгүй бол хариуцлага тооцох асуудал яригдана.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.
Б.Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Миний ойлгосноор ойролцоогоор нэг их наяд төгрөгийн АМНАТ-ын өр байх ёстой. Тэрний ихэнх нь Оюу Толгой байгаа байх.

Тэгэхээр АМНАТ дээр нэг зүйлийг хэлэхэд өөрийн ордтой аж ахуйн нэгжүүд шууд экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа. Тэгэхэд шууд ганц АМНАТ төлөөд л гарчхаж байгаа.

Гэтэл өөрийн ордгүй 22 үйлдвэр байгаа. Тэд нар энэ ордоосоо өөр лүүгээ бүтээгдэхүүн авахаар нэг АМНАТ төлөөд, бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд дахиад хилээр гаргахаар дахиад АМНАТ төлж байгаа.

Энэ бол Монголын дотооддоо үйлдвэрийг хөгжүүлэхэд маш их тийм гацаа үүсгэж байгаа.

Одоо 22 аж ахуйн нэгж бүгдээрээ 1500 хүн зогсчихсон. Өнөөдрийн байдлаар 50 тэрбум төгрөгийн АМНАТ-ын өртэй байгаа.

Хэрвээ сүүлийн 3 жил ажилласан бол ойролцоогоор 150-иад тэрбум төгрөг орон нутагтаа төлөөд ажиллаад явах боломжтой байсан байхгүй юу даа. Харамсалтай нь энэ биш.

Тэгэхээр би энэ дээр нэг хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа юм л даа. Давхардуулж олгодогийг. Энэ нь маш буруу байна гээд. Өөрөөр хэлбэл төмрийн хүдрээр хорголжин хийж байна, ширэм хийж байна, жоншоор кальцийн фтор хийж байна. Тэгээд л юу байдаг юм хагас коксжсон үйлдвэр чинь бүгдээрээ зогсчоод байгаа байхгүй юу даа.

Тэгээд бид түүхийгээр нь л экспортод бүтээгдэхүүн гаргана гэдэг чинь тэгээд л ерөөсөө хоёр хөршийнхөө л үйлдвэрлэлийг дэмжиж байна. Бид өөрсдийнхөө дотооддоо үйлдвэрлэл хөгжүүлэхгүй байх ийм л бодлого яваад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Засгийн газрын ямар бодолтой байгаа юм? Татварын ямар орчныг оруулж ирэх юм?

Миний ойлгосноор Г.Тэмүүлэн дарга хэн дарга хоёр бас дотооддоо өөрийн ордгүй, дотооддоо үйлдвэртэй тэр хүмүүсийн төлөөллийг хүлээж авсан гэсэн. Энэ дээрээ бас ямар бодлоготой байгаа юм бэ гэдгийг хэлээд өгөөч.

Хоёрдугаарт нь, Б.Заяабал даргаас яг тодорхой асуулт. Танаас би түрүүн асуусан.

Өөрөөр хэлбэл Энержи ресурс хил рүү гаргахад Цагаанхад дээр буулгаж байгаа. Тавантолгойгоос Цагаанхад хүртэл Энержи ресурсийн тээвэр хийж байгаа компаниуд НӨАТ төлөхгүй байгаа.

Гэтэл Эрдэнэс Тавантолгой, жижиг Тавантолгой зэрэг компаниудаас нүүрс аваад Цагаанхад дээр буулгаж байгаа тэр компаниуд бүгдээрээ НӨАТ төлж байгаа.

Адилхан хоёулаа экспортыг чиглэсэн бараа, бүтээгдэхүүнүүд. Яагаад хоёр өөр байгаа юм. Би танаас түрүүн хоёр ч удаа асуусан.

Тийм учраас яг тодорхой хариулттай болчихсон байгаа гэж бодоод хариулж хариултыг чинь авах гэж байна.

Яагаад ингээд компани аж ахуйн нэгжүүд дээр хоёр өөр татварын хураалт яваад байгаа юм бэ? Тэд нар нь яах вэ, жижиг ганц хоёр машинтай аж ахуйн нэгжүүд. Түүнийхээ учрыг мэддэггүй юм шиг байгаа юм. Тэгэхдээ л ер нь Эрдэнэс Тавантолгойгоос, жижиг Тавантолгойгоос экспортод гарч байгаа нүүрс бүгд НӨАТ-тай.

Өөрөөр хэлбэл Цагаанхад хүртэлх тээврийг дотоодын тээвэр гэж үзээд бүгдэнгээс нь НӨАТ авч байгаа юм.

Гэтэл Энержи ресурсийн ачиж байгаа нүүрс Цагаанхад дээр буулгахад экспортод чиглэсэн нүүрс гээд НӨАТ авахгүй байгаа. Тээвэрлэлтээс нь.

Энэ чинь хууль ингэж хоёр өөр байдлаар татвар хураалтад нөлөөлж болохгүй л гэж би үзээд байгаа юм. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Б.Жавхлан сайд хариулах уу. Тийм ээ. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй л юм асуулаа даа.

Байгаа мэдээллээ хуваалцъя.

Наадах дээр чинь саяын асуулт чинь байхгүй л дээ. Таны асуулдаг асуулт чинь байхгүй. Орлого төвлөрүүлдэг талаас нь асуух юм бол таны асуултад би эсрэг л хариулт өгөх байхгүй юу. Наадах чинь шинэ асуулт биш л дээ.

Ер нь сүүлийн арав гаруй жил явж байгаа асуудал. Өмнөх 4 жил бүр Үндсэн хуулийн цэц хүртэл явсан. Үндсэн хуулийн цэц дээрээс дүгнэлт гараад Засгийн газрын АМНАТ-ын хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа бодлого журам нь зөв байна, маргаангүй байна гээд гарсан байгаа.

Өөрөөр хэлбэл энэ Үндсэн хуулийн асуудал шүү дээ. Үндсэн хуулийн асуудал.

Үндсэн хуулийн 6.2-оор тэр АМНАТ-ыг аль болох тултал нь л аль болох өндөр хэмжээгээр, аль болох ард түмэнд хүртээмжтэй байх хэлбэрээр явах ёстой гэдэг үүрэгтэй ажилладаг.

Түүнээс таны ярьж байгаа 5 компани, 22 компанийн хувь заяаг шийдэх гэж 3.5 сая хүн дээр очих ёстой орлогыг бид бууруулж болохгүй.

Тийм учраас энэ дээр Засгийн газрын хатуу байгаа. Энэ АМНАТ бол өсөн нэмэгдэх АМНАТ. Мөн хасагдуулж тооцдог энэ зарчмаараа л явна.

Тэр тээвэрлэлттэй холбоотой НӨАТ-ыг Татварын ерөнхий газрынхан хариулчихсан нь дээр байх. Тийм юм байгаа юм уу? Би ерөөсөө мэдэхгүй байна.

Г.Тэмүүлэн: Тээвэрлэлттэй холбоотой асуудал дээр Татварын ерөнхий газар Б.Заяабал дарга. 7 номер.

Б.Заяабал: Тэгэхээр нүүрс тээвэр дотооддоо тээвэр хийж байна уу, гадагшаа хил гарч тээвэр хийж байна уу гэсэн ийм хоёр ялгаа л байгаа юм.

Хуучны хэллэгээр “**богинын тээвэр**”, “**уртын тээвэр**”, “**уртын урт**” гээд ингээд гурван ялгаатай яригддаг шүү дээ.

Тэгэхээр **уртын тээвэр** буюу уурхайгаас Цагаанхад хүртэл тээвэр дотооддоо хийж байгаа тээвэр болж байгаа. Богинын тээвэр буюу Цагаанхадаас цаашаа хил гарч байгаа экспортод чиглэсэн тээвэр болж байгаа.

Тэгэхээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль дээр экспортод чиглэсэн тээвэр хийж байгаа бол НӨАТ-

ын тэг хувь хэмжээг хэрэглэнэ буюу тэр нь тээвэртэй холбоотой гарсан НӨАТ-ыгаа буцааж авч болно гэсэн ийм хууль үйлчилж байгаа.

Дотооддоо буюу уурхайн амнаас Цагаанхад хүртэл дотооддоо хил дотроо тээвэрлэж байгаа тээвэр дээр НӨАТ-ын тэг хувь хэмжээг хэрэглэх ийм хуулийн зохицуулалт байхгүй байгаа.

Үүгээрээ тээврийн компаниуд ялгаатай байгаа юм гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Ж.Ганбаатар сайд нэмээд тодруулчих уу? Тийм ээ. Ж.Ганбаатар сайд.

Ж.Ганбаатар: Тэр боловсруулах, хагас ч юм уу. Тийм ээ. Бүтэн ч юм уу боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих асуудлаар хуулийн төсөлд ер нь “**Х**”, “**А**” гэдэг зөвшөөрөл дээрээ нэмээд “**Б**” зөвшөөрөл гэдгийг гаргаж байгаа. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Тэгээд ирээдүйн зорилго нь ямар нэгэн байдлаар. Би тэгэхдээ АМНАТ-ыг нь яриагүй шүү. АМНАТ-ыг Сангийн сайд зөв томъёоллоо л доо.

Ер нь заавал төлөх ёстой. Экспортод нь ч байсан, дотооддоо боловсруулсан байсан ч энэ чинь Үндсэн хуулийн заалттай учраас заавал төлөх ёстой.

Тэгэхдээ энэ Сангийн яам хасдаг юм шиг байна лээ л дээ. Тэр 2.5-ыг экспортод гаргахдаа тэр авсан 2.5-ыг нь хасаад өгчихдөг юм байна лээ л дээ.

Гэхдээ тэр үнийн зөрүү дээр нь л нэг асуудал үүсээд байдаг юм шиг байгаа юм.

Тэгэхээр бид яах гэж байгаа вэ гэхээр “Б” зөвшөөрөлтэй болгож байгаа. Үүнийг Сангийн яаманд хэлээд Сангийн яамныхан бас энэ асуудал дээр анхаарал тавьж ажиллаж байгаа.

Энэ тохиолдолд орхигдсон байгаа салбарыг цаашдаа яаж зохицуулах вэ гэдгийг л зохицуулахын тулд дэмжлэг маягаар гэсэн үг шүү дээ. Энэ зөвшөөрөлтэй болгож өгч байгаа.

Энэ тохиолдолд тэгээд хууль санаачлагч нар энэ салбараа яаж дэмжих юм. Хуулиа боловсруулаад. Тэгэхгүй бол энэ хүмүүсийг чинь тэгээд хаана хэн юу хийж байна, та тэдэн үйлдвэр тэнд байна, тийм байна гээд хэлчихнэ. Үүнийг чинь бүгд ямар нэгэн байдлаар бүртгэл юу байхгүй. Хэн хаанаас зөвшөөрсөн юм.

Тэгэхээр Ашигт малтмалын хуульд тийм зохицуулалт оруулж байгаа.

Тэр НӨАТ-ын хувьд хэлэхэд тэр боловсруулах үйлдвэрийг дэмжих тэр үнслэг маш багатай, тэр угаах үйлдвэрүүд, угаасан нүүрс гаргах тэр асуудлаар тодорхой дэмжлэгүүд явж байсан юм билээ. НӨАТ-ын. Одоо зогсчихсон байгаа. Одоо огт зогсчихсон байгаа шүү. Буцаан олголт гээд 502 гээд Сангийн яамныхан мэддэг байлгүй дээ. Одоо бол тэр нь огт зогсчихсон байгаа.

Тэрийг яах вэ, Уул уурхайн яам тэр боловсруулах үйлдвэрийг дэмжих хүрээнд тэр асуудлыг Засаг руу оруулсан. Одоо тэр нь зогсчихсон байгаа юм билээ.

Г.Тэмүүлэн: Б.Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ардын намын хэдэн сайд нар том дуугаар хариулахаар лаг гэж бодоод байх шиг байгаа юм.

Би ерөөсөө Монголд үйлдвэрлэл хөгжүүлэхийн төлөө дэмжиж ажиллана. Хангалттай.

Гэтэл тэр давхардуулж авсан АМНАТ-аас чинь болоод 22 үйлдвэр бүгдээрээ зогсчихсон. Болсон болоогүй 40 тэрбум төгрөг төлдөг байсан байхгүй юу даа.

Тэгсэн чинь 1500 хүн нь ажилгүй болчихсон. Дээрээс нь тэр 22 үйлдвэр чинь бүгдээрээ хаагдчихсан. 1500 хүн нь хотод ороод ирчихсэн. Тэгээд болсон болоогүй төлж байсан тэр үйлдвэрүүд чинь одоо юу ч төлөхөө больчихоод байгаа байхгүй юу.

Тэгээд дотооддоо үйлдвэрлэлийн үе шат чинь шат шатаар хөгжиж дэвшиж явж байж энэ чинь эцсийн бүтээгдэхүүн гаргадаг л байхгүй юу даа.

Тэр юмыг хаачхаад. Тэгээд юу ч төлөхгүй, байхгүй болчихсон аж ахуйн нэгжүүдийг би лоббидоод яах вэ дээ.

Ирээдүйд хэрэгтэй байхгүй юу даа. Дампуурчихсан аж ахуйн нэгжүүдийг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Б.Пүрэвдорж гишүүн ээ.

Энэ АМНАТ наадах чинь бас л жоохон попролтын л нэг хэлбэр шүү. Энэ бол албан татвар гэхээсээ илүү татварын нэг хэлбэр. Тэгэхдээ энэ бол төлбөр гэсэн үг.

Роялти ч гэж олон улсын хэллэгээр нэрлэдэг. Өөрөөр хэлбэл

хаандаа төлж байгаа л өргөл барьчихсан юм шүү дээ. Санаа нь, агуулга нь.

Өөрөөр хэлбэл Монгол Улсад хаан нь ард түмэн. Ард түмний баялгийг газар доороос ашигласныхаа төлөө ард түмэндээ төлж байгаа л төлбөр байгаа юм.

Үүнийг аль болох ахиу л авах ёстой. Хүртээмжтэй байдлаар авах ёстой. Одоо боловсруулалтыг дэмжих, эцсийн бүтээгдэхүүн хүртэл тултал боловсруулалтыг дэмжих нь бид өөр татварын бодлогоор байж болох олон янзын хувилбар байна.

Жишээ нь, ирэх жил одоо яг уул уурхайн салбарт шүү. Уул уурхайн салбарт боловсруулах шат дээр яг технологийн орж ирж байгаа.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд нэмээд тодруулчихъя. Микрофон нэмж өгье.

Б.Жавхлан: 2024 онд жишээ нь төсөв батлагдсантай холбогдуулаад орсон нэг өөрчлөлт бол боловсруулах үйлдвэрүүд, ялангуяа уул уурхайн салбар дээр шүү.

Одоо тоног төхөөрөмжийг нь бүгдийг нь гаалийг нь тэглэж байгаа. НӨАТ-ыг нь 2-оос 4 жил хойшлуулах ийм боломжуудыг нь тавьж байгаа.

Өөр бусад татварын ямар бодлогууд байж болох вэ. Энэ дээрээ ажиллаж байна.

Харин АМНАТ дээр бид очтолоо тэгж яармааргүй байгаа юм. Энэ ард түмэнд очих ёстой орлого байдаг учраас. Тийм л бодлого байгаа.

Г.Тэмүүлэн: Б.Пүрэвдорж гишүүн сүүлийн тодруулга. Нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: АМНАТ-ыг давхардуулж авдаг ганцхан орон дэлхийд байдаг юм. Тэр нь Монгол л байдаг юм. Өөр орон олоод ирээрэй.

Тэгээд Б.Заяабал дарга аа, яг тэр Тавантолгойгоос Цагаанхад хүртэл адилхан л тэнд буулгаад л цаашаа тээвэр хийж байгаа.

Нэгээс нь НӨАТ аваад, нөгөөдөхөөс нь НӨАТ авахгүй байгаа энэ үйлдэл чинь нэг компанид хэт их давуу эрх мэдэл өгсөн албан тушаалын гэмт хэрэг шүү.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд тайлбар өгье.

Б.Жавхлан: Б.Пүрэвдорж гишүүн уг нь өөрөө гаалийн салбарын хүн аягүй сайн мэддэг л байх ёстой доо.

Тэр АМНАТ-ыг давхардуулж авч байна гэдгийг та давхардуулж авсан, давхардуулж төлсөн нэг аж ахуйн нэгж байвал та олоод ир.

Тэр чинь хасагдуулж тооцдог. Хасагдуулж тооцдог. Тэрийг давхардуулна гэдгийг буруу тайлбарлаад олон нийтэд буруу ойлголт өгөхөөр ингээд яваад байдаг байхгүй юу.

Давхардуулж авсан юм ерөөсөө юу ч байхгүй байгаа. Харин НӨАТ яах аргагүй хууль нь тийм байгаа юм чинь хууль зөрчиж бид өөр байдлаар энэ татварыг дураараа үзэмжээрээ шийдэж ерөөсөө огт болохгүй.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Аудитын тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд байгаа юу? Алга байна.

Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаар аудитаас гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

Ингээд нэг талдаа төрөөс явуулж байгаа татвартай холбоотой бодлого шийдвэр үр дүнтэй байх ёстой. Байгаа онодог байх ёстой.

Тэгэхээр энэ дээр бид хэрэв алдаа, зөрчил, дутагдал, одоо юу гэдэг юм аудитаас гаргасан тайлантай холбогдуулж байгаа бол бид үүнийг тодорхой Байнгын хорооноос залруулах арга хэмжээг авна.

Шалгахдаа дараагийн Байнгын хороон дээр Байнгын хорооны тогтоол болоод, шийдвэрийн төслийг оруулж ирнэ.

Сангийн яам сая аудитын гаргасан дүгнэлт болоод сая 3.2.3-тай холбоотой аудитыг нь тодорхойлсноор “**хуулиас давсан журам байна**” гэдэг асуудал байгаа. Сангийн сайдын тушаалаар.

Тэгэхээр энэ дээрээ Сангийн яам тодорхой албан бичгээр Байнгын хороонд тайлбар, мэдээллийг ирүүлээрэй гэдгийг хэлэх байна.

Ингээд аудитын тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа орцгооё.

Зургаа.Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлан

Зургаа. Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаарх Үндэсний Аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсэг Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Я.Самбууням Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, М.Мэндбаяр Уул

уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Э.Батболд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Отгонцэцэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Л.Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Б.Заяабал Татварын ерөнхий газрын дарга, Г.Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, А.Энхболд Татварын ерөнхий газрын дэд дарга, Б.Энхбат Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Н.Эрдэнэ Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Орлогын хэлтсийн мэргэжилтэн,

Б.Даваасүрэн Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газрын дарга, Д.Цогтжаргал Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга, Б.Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Д.Сайханчулуун Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга, Н.Мөнхбилэг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн хэлтсийн дарга, Б.Эрдэнэбат Гаалийн ерөнхий газрын Татвар, тарифын газрын гаалийн улсын ахлах байцаагч, Б.Болормаа Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын удирдлагын менежер, Л.Мөнхцацрал Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор, Ү.Төгсжаргал Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитор, Д.Энхтуяа Үндэсний аудитын газрын Мэдээллийн технологийн төвийн шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна.

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт болоод гүйцэтгэлийн талаарх Үндэсний аудитын газраас гүйцэтгэсэн аудитын тайлангийн танилцуулгыг Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг дарга танилцуулна.

Ц.Наранчимэг даргыг микрофонд урья.

Уул уурхайн сайд Ж.Ганбаатар байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд.

Ц.Нарантуяа: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл сэдэвт аудитаар төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг болох уул уурхайн салбарын орлогыг хэрхэн бүрдүүлж буй нөхцөлийг тодруулж, дүн шинжилгээ хийн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитаар дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

-Уул уурхайн салбарын 2019-2022 оны төсвийн орлогын төлөвлөлт оновчтой эсэх;

-Уул уурхайн салбарын 2019-2022 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх асуудлыг аудитад хамруулж гүйцэтгэсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэлгээг олон улсын зах зээлийн жишиг үнээр үнэлэн түүнээс хүртэх ашиг, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг холбох, зах зээлийн бодитой ханш тогтоох, хөрөнгө оруулжил оруулагчдыг найдвартай мэдээллээр хангах, татвар хураамжийг үндэслэлтэйд тооцох зэрэг нээлттэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн дараах хууль, тогтоомж болон Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд батлагдсан байна. Үүнд:

“Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль тогтоомжуудаар аудитад хамаарууллаа.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжээгүйгээс баялгийн сан төвлөрөх, орлого буурах, нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

Уул уурхайн салбарын төсвийн орлогын төлөвлөгөөг улсын эдийн засгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагын мэдээллийг үндэслэж боловсруулаагүй байна.

Сангийн яамнаас уул уурхайн салбарын төсвийн орлогын хэмжээг тооцохдоо голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, экспортын хэмжээ болон макро эдийн засгийн төсөөлөл зэргийг үндэслэсэн байна.

Сангийн яам дараах хууль тогтоомжийг үндэслэн уул уурхайн төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулдаг байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан хувь хэмжээ, Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоол, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хувь хэмжээ, гаалийн албан татвар хураамж, нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад орлогын төсөөллийг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харгалзан тус тус тооцож байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн орлогын дүнгийн 25.6-аас 29.6 хувийг уул уурхайн салбарын орлого эзлэхээр төлөвлөсөн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны салбарын орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулахад 1-ээс 15.9 хувиар давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөө хамгийн өндөр буюу 29 хувиар давж биелсэн байна.

Энэ нь тайлант хугацааны төсвийг батлахдаа КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал, хилийн хоригоос шалтгаалж нүүрс, зэсийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний экспортын хэмжээг бууруулан төлөвлөсөн боловч 2022 оны эцэст дээрх нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс нүүрс, зэсийн баяжмал, цайрын орлогын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 18.5 их наяд төгрөгт хүрснээс уул уурхайн салбарын газрын тосны бүтээгдэхүүний орлого тус онд 5.5 их наяд төгрөг буюу 2019 онтой харьцуулахад 2.1 их наядар 1.8 хувийн өссөн үзүүлэлттэй байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний 2022 оны төсвийн орлогын 52.8 хувийг АМНАТ, 20.1 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 27.1 хувийг бусад татвар хураамж эзэлсэн бөгөөд АМНАТ-ын 2.9 их наяд төгрөгийн орлогоос Тогтворжуулалтын санд 1.1 их наяд, Ирээдүйн өв санд 1.0 их наяд, улсын төсөвт 615.5 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Татварын алба улсын хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн

байдлаар 244 мянга 346 татвар төлөгч хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй 846, тусгай зөвшөөрөлгүй 266, үүсмэл ордын 1, нийт 1113 татвар төлөгч хуулийн этгээдийг хамруулсан.

Тайлант хугацаанд 2019-2020 оны давхардсан тоогоор 503 тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн 172 ашиглалтын, 451 хайгуулын тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлснээр 43.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Уул уурхайн салбарын төсвийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 2019-2022 онд 12.5 их наяд төгрөгийн татварын ногдуулалт хийснээс аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 31.8 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 5.6 хувь, хүн амын орлогын албан татвар 4.2 хувь, АМНАТ 55.1 хувь, бусад 3.3 хувийг эзэлж татварын дээрх хэмжээ хугацаанд нь 2.2 их наядаар нэмэгдсэн байна.

Уул уурхайн салбарын татварын орлогыг мөн 12.8 их наяд төгрөг төвлөрүүлснээс аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 4.1 их наяд, АМНАТ 6.5 их наяд, нэмэгдсэн өртгийн албан татвар 560.2 тэрбум, хувь хүний орлогын албан татвар 593.6 тэрбум буюу бусад хураамж 982.2 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчдийн татварын өрийн хэмжээг авч үзэхэд Татварын албанд 2023 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар 3.2 их наяд төгрөгийн татварын өр, аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлангийн ноогдлын дутуу үлдэгдэлтэй байгаагаас уул уурхайн салбарын татвар төлөгчдийн

татварын өр тайлангийн ногдуулалтын дутуу үлдэгдэл 1.1 их наяд төгрөг буюу нийт татварын албаны өр төлбөрийн 35.2 хувийг эзэлж байна.

Аудитаар бид дараах дүгнэлтийг өглөө.

Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт удааширсан нь баялгийн санд төвлөрүүлэх орлого буурахад нөлөөлсөн байна.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрөл **эзэмших, шилжүүлэх, бүртгүүлэх** үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь холбогдох төрийн байгууллагуудын тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

Уул уурхайн салбарын экспортын бүтээгдэхүүнээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой тооцох, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлснээр төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангагдах боломжтой байна.

АМНАТ-ийн ногдуулалт, тайлагналд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх боломж байна.

Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгээгүй, үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүй нь татварын байгууллагаас АМНАТ-д ногдуулах боломжийг алдагдуулж байна.

Аудитаар илэрсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сангийн яаманд:

Сангийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газрын тосны газар зэрэг байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, технологийн шийдлийг холбогдох бодлогын яамтай хамтран боловсруулж шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд:

Хууль эрх зүйн актад тусгасан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, үр дүнг тооцож тайлагнаж байх.

Ашигт малтмал, газрын тосны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Ашигт малтмалын ордын геологийн болон үйлдвэрлэлийн нөөцөд бүртгэсэн үндсэн болон дагалдах ашигт малтмалын талаарх хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

Ашигт малтмал, газрын тосны газарт:

Ашигт малтмалын тух тусгай зөвшөөрлийг шинээр олгох, шилжүүлэх,

эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүрд нь төрийн байгууллагуудад мэдээллийг хүргүүлж байх.

Татварын ерөнхий газарт:

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг бусад төрийн байгууллагуудын цахим системтэй уялдуулж, мэдээ, мэдээллийг бодит цагийн горимоор авах боломжийг бүрдүүлж, солилцсон мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаандаа байгаа эсэхт дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.

Уул уурхай салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх талаар мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн актыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцож ажиллах гэсэн эдгээр зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ц.Наранчимэг даргад баярлалаа.

Тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Ж.Батсуурь гишүүн, Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ж.Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Түрүүнд би асуугаад хариултаа авч чадаагүй л дээ.

Тэгэхээр мэдээж татварын шинэчлэлийн бодлого яваад, татварын цар хүрээ өсөөд, ололттой талууд маш их байгаа гэж ярьж байна. Үүнийг бас хүлээн зөвшөөрч байгаа. Хүлээн зөвшөөрч байгаа.

Гэхдээ цаашид мэдээж татварын энэ шинэчлэл улам л төгөлдөржөөд явах ёстой байх.

Тэгээд би түрүүнд асуугаад аль нь ч хариулаагүй.

Уул уурхайгүй ээ, бид эко аймаг, бид аялал жуулчлалын бүс нутаг гээд орлого олдоггүй, улсын төсөвт төвлөрүүлдэггүй, улсын төсвөөс байнга татаас авч байдаг. Тэгээд тэрийгээ нэг гайхуулж байдаг юм шиг хэдэн аймгууд байдаг шүү дээ.

Тэгсэн мөртөө тэрнийх нь үйлийг үзээд уул уурхайгаараа сайлуулж муулуулаад газар нутаг, бэлчээр, өвөлжөө, хаваржаа бүхий л зүйлээ, улс орны нийтлэг эрх ашгийн төлөө боомт бүх зүйлээ ашиглуулаад сайн мууг нь олчоод тэр олсон орлогыг тэр газар луу хуваарилаад байдаг юм.

Та нар юу гэж хариулах вэ гэхээр Монгол нэгдсэн улс, нэгдсэн төсөвтэй гэж хариулна.

Тэгэхдээ аливаа хуулийн үзэл санаа чинь шударга зарчим дээр тэнцүүлэн хуваарилах зарчим дээр байдаг биз дээ. Хэн их хөдөлмөрлөнө вэ түүнийхээ үр шимийг хүртэх ёстой, хэн сайн ажиллана вэ тэр ард түмэн илүү сайхан амьдралын төлөө төрийн дэмжлэгийг авч байх ёстой.

Гэтэл нөхцөл байдал эсрэгээрээ байдаг. Олон удаа хэлж байна.

Тэгэхээр үүнийг дараа дараагийн зүйлүүд дээр юу гэж анхаарч ажиллая гэж боддог юм.

Тэгээд орон нутгийн хөгжлийн сан ярьж байна л даа. Сайд. Орон нутгийн хөгжлийн санд дөнгөж сая та нар

төлөвлөснөөр чинь өгнө, хуулиар чинь өгөхгүй гээд хоёр жилийн зөрүү өгөх гээд арваад тэрбум төгрөг болчхож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг арилгах ёстой. Шударга зарчимд. Ядаж шударга биш байдаг юм гэхэд 40 хувьд оногдох мөнгийг нь бүрэн өгмөөр байгаа юм. Бүрэн өгмөөр байна.

Дээр нь түрүүн Сангийн сайд хэлж байсан. Зарим үед ковидоос болоод энэ тэр гэдэг юм уу, бас дутах. Түрүүн 2022 онд Дархан хотод очсон байна шүү дээ. Төмөрлөгийн үйлдвэр гээд.

Үүнийг эрсдэлийн сангаас өгөх ёстой шүү дээ. Эрсдэлийн сан гэж байдаг шүү дээ. Угаасаа эрсдэнэ гээд сан үүсгэж явдаг.

Тийм учраас тийм эрсдэл үүссэн газрыг төлөвлөгөөнөөс давсан хэсгээр нь булааж аваад дутсан хэсэгт нь өгнө гэдэг бол өөрөө нэгдүгээрт хууль зөрчинө.

Хоёрдугаарт, шударга зарчимд нийцэхгүй. Тийм болохоор гол татвар яриад эхлэнгүүт уул уурхайтай л болоод явчихдаг.

Энэ дээр ярьж байна л даа. 29 хувь гэдэг чинь 30 хувь л гэсэн үг л дээ. Тэгэхээр чинь нийт орлогын 30 хувийг бүрдүүлж байна.

Тийм учраас хэдүүлээ уул уурхайтай холбоотой асуудлуудаа зөвхөн татвар гэдэг биш иж бүрнээр нь харах, тэрний хөгжил дэвшил, ирээдүй.

Уул уурхайн татварыг нэмэгдүүлье гэж байгаа бол тэнд байгаа бааз суурийг нэмэгдүүлж урамшлыг нь олгож байж л ахиад энэ чинь 35 хувь, 40 хувь болж явна.

Тэгэхгүйгээр нөгөө хэдийгээ ноолоод байх юм бол энэ чинь 25 руу, 20 луу болоод ямар ч урам байхгүй шүү дээ. Хөдөлмөрлөлөө, хийлээ, зүтгэлээ гээд.

Тэгэхээр энэ тал дээр онцгой анхаарч ажиллах ёстой.

Тийм учраас нэгэнт л тайлан сонсож байгаа учраас өмнөх алдааг заавал хууль руу чихээд, журам руу чихээд байхгүйгээр шийдвэрлээд дараагийн төлөвлөлтүүд дээрээ л энэ алдаа гаргахгүй байхаар л явах хэрэгтэй байна гэсэн ийм зүйл хэлж байна. Асуулт.

Г.Тэмүүлэн: Ж.Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Тийм. Тантай санал нэг байна. Би яг тодорхой хариулт өгье.

Тийм ч учраас яг таны үүсэж байгаа асуудал үүсэж байгаа учраас Уул уурхайн яамнаас Ашигт малтмалын хуулийн төсөл 03 сарын 01-нд Их Хурлын гишүүдэд тараагдсан.

Сая бас 10 сарын 01-нд төслийг шинэчлээд саналуудыг тусгаад Их Хурлын гишүүдээр цонхоор тараагдсан байгаа.

Энэ төсөл дээр бид Сангийн яамныхан байгаа. Бид хуульд 10 хувь гэж байгаа. Ашигт малтмалаа ашиглуулсан сум, аймаг АМНАТ-ын орлогын 10 хувийг аймаг, сумд нь үлдээнэ.

Бид үүнийг 30 хувь болгож өсгөсөн байгаа. 10 хувийг нь сумд нь, 20 хувийг нь аймагт гээд төсөл дээр яг биччихсэн байгаа. Та хараарай. Тэгээд төслийг дэмжиж өгөөрэй.

Тэгсэн тохиолдолд аймаг, сум ашигт малтмалаа ашиглуулж байгаа орон нутаг хөгжих тэр суурь үүснэ. Бид тэгж харж байгаа.

Тийм учраас бид төсөлд тэгж тусгасан байх гэдгийг хэлье. Дууслаа.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батсуурь: Сая төсвийн ажлын хэсэг дээр би олон санаа хэлээд цөөнх болоод бараагүй л дээ.

60 гээд заачхаж байгаа юм. Энэ аягүй буруу. Орон нутагт АМНАТ дээр 60.

Яагаад вэ гэхээр би тэрийг юу гэж тайлбарлаж байсан гэхээр түмпэнд хивс угааж болдоггүйтэй адилхан нэг жижигхэн сум. Том бодлогын асуудал явахгүй байхгүй юу. Уул уурхайтай байлаа гэхэд тэнд багтаж шингэхгүй их мөнгө хуваарилагдаад байгаа байхгүй юу. 60 гээд хуваарилчихсан учраас.

Тэгэхээр 60 хүртэл гэх юм бол аймгийн гэдэг юм уу, хотын гэдэг юм уу том бодлогынхоо хүрээнд хооронд нь интервалтай зохицуулж болохоор байгаа байхгүй юу.

Тэгээд би төсвийн ажлын хэсэг дээр хэд санал хураалгаад хүрээгүй. Жишээлэх юм бол нэг жижигхэн сум. Онцын төвлөрөл багатай биш сумын нутаг дэвсгэр дээр том уурхай байлаа гэхэд тэднээсээ хүсээгүй их мөнгө очиж байгаа байхгүй юу. Хүсээгүй их мөнгө.

Тэгтэл чинь өөр маш олон хүн амтай том газар нутагтай сум байлаа гэхэд хүссэн хэмжээнийх нь мөнгө нь очихгүй байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тодруулчих уу? Ж.Батсуурь гишүүн нэмээд микрофон дээр тодруулаад хэлье.

Ж.Батсуурь: Тэр зурлагыг орон нутгийн хуралд нь эрх мэдлийг нь 60 хүртэл гээд өгөх юм бол яг Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” гэдэг юм уу, “Хөдөөг дэмжих бодлого” гэдэг юм уу энэ бодлогод тулгуурласан бодлого тэнд явагдах бүрэн боломжтой.

Шууд хатуу хуульчилчихаар дээрээс тээр доор байгаа зүйлийг чинь олигтой харж мэдэрч чадахгүй шүү дээ.

Тийм учраас ийм уян хатан байх ёстой.

Дээр нь ер нь энэ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдлийг дээшээ зулгаасны гор төсвийн хууль дээр ч гарч байна, Засгийн газрын чиг үүрэг орон нутагт яг оновчтой очиж чадахгүй байгаа юм.

Тийм учраас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад ерөнхий интервал дээд хязгаар гэдэг юм уу, эрх хэмжээнийх нь дээд хязгаарыг өгөөд үлдсэн зохицуулалтуудыг нь өг гэдэг энэ заалтуудыг дагасан хуулиудаар хасдаг асуудлыг л зогсоох ёстой л гэж хэлмээр байна.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд тодруулж тайлбар өгье.

Б.Жавхлан: Яах вэ, Ж.Батсуурь гишүүн ээ, наадах чинь хоёр талтай л даа.

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилалтыг нь тухайн аймаг, бүс нутагтаа уул уурхайн салбараа илүү их эргэлтэд оруулах тусмаа л тийшээгээ илүү хүртэж байдаг байдал руу нь бид

нар ингээд алхам алхмаар өөрчлөөд явж байна.

Тэр бол яг саяын таны хэлж байгаа Хөдөө орон нутгийн хөгжлийн холбоотой.

Тэгээд янз бүрийн босоо, хэвтээ хөдөлгөөнүүд гарч ирээд л. Тэгээд тэд нартай орон нутгийнхан нийлээд л зогсоогоод л, ингээд л байдаг энэ явдлуудаасаа эсрэг үр дүн гардаг. Ард түмэн нь өөрсдөө тэнд хариуцлагатай уул уурхайг ажиллуулаад. Тэр тусмаа сайхан амьдардаг, амьдралын чанар нь сайжирдаг ийм л болгох гэж байгаа юм.

Яах вэ, одоо аймгийн түвшинд нь аваачаад аймгаас цаашаагаа бүр сумын түвшинд нь илүү хуваарилалт хийсэн. Ийм алхам хийсэн. Үнэн.

Гэхдээ үүнийг та буцаагаад 60 хүртэл нь гээд ингээд задгай тодорхойгүй орхичихвол сум руугаа очихгүй аймгийн дарга нар нь барьж авчих.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сангийн сайд нэмж тайлбараа гүйцээгээд өгье.

Б.Жавхлан: Тийм.

Тэгэхээр энэ хоёр талтай шүү. Зарим сумдын дарга нар ч хэлж байгаа. Ингээд орхичих юм бол аймгийн дарга тэнд аймгийн төв дээр хамаг хуваарилалтаа барьчхаад бидэнд ноогдохгүй ээ гээд.

Тэр чинь хэрвээ тэгэх юм бол яг л таны түрүүний ярьдаг нэгдсэн улсын гэдгээрээ аймгийн түвшинд бид чинь нэгдсэн аймаг шүү. Ганцхан сумаас тогтдоггүй гэдэг бас л нэг ийм зөрчил үүснэ шүү дээ.

Тэгээд хоёр талтай юм. Тэгээд амьдрал яаж харуулах нь вэ. Ямар ч байсан бид орон нутгаа дэмжих тал руу нь их том бодлогын шийдвэр өөрчлөлт гаргасан.

Тийм учраас ямар ч байсан 2024 ондоо үүнийгээ хийгээд л үзье.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батсуурь: Ойлгож байна, ойлгож байна. Хоёр талтай. Гуравдагч тал бас байж болж байгаа юм.

Тэгэхээр ингэмээр байгаа байхгүй юу. Ерөнхий хөгжлийн бодлогодоо чиглэсэн газар нутаг, хүн амтай харьцуулсан ийм бас гурав дахь хувилбар байж болох юм л даа.

Тэгэхгүй бол ингэж байгаа юм. Хил дээр байдаг жижигхэн сум өөрөөсөө хэтэрсэн мөнгө авдаг.

Гэтэл төвд нь байдаг сумын тэр газар нутаг дээгүүр нь дайран өнгөрдөг. Тэгсэн мөртөө уул уурхайгүй. Хамгийн их хэлмэгдлийг нь авч байдаг энэ сум татваргүй үлдээд байдаг байхгүй юу.

Тэгэхээр энэ зохицуулалтыг заавал 60 хүртэл гэж хэлж болдоггүй юм бол ахиад тэнд нь өөрөө газар нутаг, тухайн нөхцөл байдлыг хүн ам, нөхцөл байдалтай нь уялдуулсан гэж оруулах юм бол нэгдсэн бодлого чинь яг бүрэн үйлчилнэ ээ л гэсэн ийм санааг илэрхийлээд байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ж.Ганбаатар сайд тайлбар өгөх үү, үгүй юү? Ж.Ганбаатар сайд тайлбар өгье.

Ж.Ганбаатар: Би үг хэлнэ. Тийм. 4 минут бас явчихлаа.

Би аудитын тайлангийн ихэнхтэй нь санал нэг байгаа. Гэхдээ нэг зүйлийг тодруулж хэлье.

Төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн гэдэгтэй санал нийлэхгүй байна. Энэ жил чинь түүхэнд байхгүй орлого нэмэгдэж байгаа биз дээ. Аан. Ямар тоон мэдээллийг надад өгөөд миний үгийг няцаах вэ гэдгийг аудит надад буцаад тайлбараа өгөөрэй.

Хэдэн сая тонн нүүрс гаргана гэж төлөвлөөд хэдэн сая тонн нүүрс гаргаж байгаа билээ? Биржээр нүүрс зарснаараа хэдэн доллароор нүүрс зарж байсан өнөөдөр хэдэн доллароор нүүрс зарж байна, үүнийг хэн хийж байгаа юм. Засгийн газар, Уул уурхайн яам хийж байгаа биз дээ.

Тэгээд яагаад дутуу төвлөрүүлсэн гэж тайлбарлаад. Ихэнхтэй нь би санал нийлж байгаа.

Ж.Батсуурь гишүүн ээ.

АМНАТ-ын орлогын тэр биелэлт гээд

-2019 онд уул уурхайд төвлөрүүлсэн орлого **3 их наяд**,

-2020 онд **2.8 их наяд**,

-2023 онд 10 сарын байдлаар **6.5 их наяд**.

Үгүй ээ, энэ чинь доо даблдчихсан байгаа юм биш үү. Аан.

Тэгээд юуг дутуу төвлөрүүлсэн гээд байгаа юм? Тэр зэс, алт. Алт арай дутуу байгаа. Зэс, нүүрс, бусад ашигт малтмал хэдэн хувиар давж биелсэн. Энэ ямар бодлогын үр дүн юм. Яагаад

биелсэн юм. Энэ тэгээд яагаад давж биелээд байгаа юм. Ямар бодлогын үр дүн юм. Яагаад ашигт малтмал наяхан доллароор зарж.

Түүхэндээ **60 доллар, 80 доллар, 90 доллар**оор зарж байсан юм. Өнөөдөр яагаад **180 доллар**оор зарж байгаа юм. Хэний ямар бодлогын үр дүн юм.

Дэлхийн ханш биш ээ. Дэлхийн ханш өндөр байхад нь зарж чадаагүй. Бирж байгуулагдсаны үр дүн.

Тэгээд буруу тайлбарлаж байна. Би тэгээд Их Хурлын гишүүний хувьд үгээ аваад ярьж байгаа юм. Сайдын хувьд биш.

Тэгээд ихэнхтэй нь би санал нийлж байгаа.

Ж.Батсуурь гишүүн ээ.

Ихэнхтэй нь нийлж байгаа юм. Зарим хүмүүс яах вэ зүгээр дунд нь юм хаяад бас жоохон бүр хэрэлдүүлэх сонирхолтой байх шиг байна.

Ихэнхтэй нь нийлж байгаа. Тэгэхдээ зарим зүйл, заалт дээрээ нэг жоохон асуудлыг бас нэг хараад өнөөдрийнхөө тоо баримтаа сайхан харна.

Тэр Ерөнхий аудит нь хаачсан юм. Тэгээд тоо баримтаа сайн хараад тоо баримттай ярих хэрэгтэй шүү.

Би тэр дагалдах ашигт малтмал гэдэг дээр нэг зүйл хэлье. Сайн уншаарай. Дагалдах ашигт малтмалаас АМНАТ авна гэдэг нь яг манай хуулиар яг нарийвчлаад зохицуулчихсан заалт байхгүй.

Өнөөдөр Сангийн яам бүх ашигт малтмалаас нь авч байгаа. Дагалдах. Дэлхийн жишиг бол зөвхөн эдийн засгийн үр ашигтайгаас нь л авдаг. Үүгээр шүүх дээр маргаан явдаг юм билээ.

Тэгэхээр манай ашигт малтмал хэрвээ хортой дагалдах ашигт малтмалтай бол цаашаа зарахад үнэ нь унадаг юм шүү. Тэгээд үүнээс нь авна гээд байвал энэ чинь ямар ч утгагүй болно.

Ирээдүйд Монголд хөрөнгө оруулах хүнгүй болно шүү. Үүнийг бас ойлго.

Энэ чинь тэгээд бид өнөөдөр хуульдаа үүнийг өөрчилж байгаа юм. Яг ямар утгатайг нь АМНАТ авах дагалдах ашигт малтмал вэ гэдгийг хуулийн төсөлд өөрчилж байгаа.

Тэгэхгүй бол дагалдаж байгаа болгоноос нь авна гэвэл хэн ч орж ирэхгүй шүү. Ингээд тайлбар хийнэ гэвэл зөндөө тайлбар байгаа.

Тэгэхээр тэр агуулгыг нь сайн ойлгоод манай яамныхан ч тайлбар аваад, эсвэл надаас ч тайлбар авах хэрэгтэй л дээ. Надаас ч тайлбар аваад тэгээд танилцуулж байвал уг нь сайн.

Би зүгээр тайлбарлах өнгө аясаар ярилаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ж.Ганбаатар сайд.

Би таныг санал хэллээ гэж ойлгох уу? Ж.Ганбаатар сайд санал хэллээ гэж ойлгож байна шүү. Тэгээд та Улсын Их Хурлынхаа гишүүний хувиар санал хэллээ гэж ойлгож байна.

Би танаас Засгийн газрын гишүүний чинь хувиар хоёр, гурван асуултууд асууна.

Аудитаас уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл дээр гүйцэтгэлийн аудитын тайланг хийсэн байгаа.

Үүнтэй холбоотой хоёр, гурван асуултуудыг би нэмж тодруулахаас аргагүй болчихоод байгаа юм. Өнөөдөр үндсэндээ Монгол Улсын төсвийн орлогын бараг 30 орчим хувийг уул уурхайн салбараас бүрдүүлж байна.

Нийт экспортын бүтээгдэхүүний бараг дийлэнх хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байгаа.

Тэгэхээр энэ өөрөө нэг талдаа өнөөдрийн Монгол Улсын эдийн засаг болоод нийгмийг авч явж байгаа томоохон салбар. Энэ дээр бид нарын хувьд тодорхой хэмжээнд мэдээж хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэ салбарынхан маань хариуцлагатай байх зайлшгүй шаардлага байгаа гэж харж байгаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой 1.18 дээр Ашигт малтмал, газрын тосны газар болгоод Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас ирүүлсэн гол нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын мэдээг харьцуулж гаргасан байгаа.

Тэгээд би хамгийн сүүлийн буюу яг 1.18-ын 2022 онд нэгтгэсэн дүн дээр нь экспортолсон бүтээгдэхүүнийх нь тоо хэмжээг аваад үзэхээр Гаалийн ерөнхий газар 31.7 сая тонн гэж гаргасан байгаа юм. Экспортын тоо бүтээгдэхүүнийг. Нийт нүүрс дээр. Би нүүрс дээр анхаарч ярьж байгаа.

Гэтэл Татварын ерөнхий газар 29 сая гэсэн дүн гаргасан байгаа юм. 2022 оны жилийн эцсийн байдлаар. Ашигт малтмал, газрын тосны газар 5.3 сая гэж гаргасан байгаа юм.

Тэгэхээр энд одоо би жишээ нь алдаа бол мэдээж биш байх гэж хараад байгаа юм. Ингээд нэг байгууллага нь бараг 32 сая гээд байдаг. Гэтэл Ашигт малтмал, газрын тосны газрынх бараг 5.4 сая гээд. Энд зөрүү үүсэж байгаа нь бараг 25 сая тонны нүүрсний асуудал үүсэж байгаа юм.

Тэгэхээр яагаад энэ төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санд байгаа энэ тоо, бүтээгдэхүүний хэмжээ, экспортын тоо хэмжээ ингэж зөрүүтэй байгаад байна вэ?

Энэ дээр эсвэл хэрэглээн дээр нь Та бүхэн байгууллагынхаа үйл ажиллагаа, чиг үүрэг дээр уг нь бүх мэдээллүүдийг нэгтгэх ёстой. Мэдээллийн нэгдсэн систем уг нь байх ёстой. Засгийн газрын зүгээс цахим шилжилтийн асуудлуудыг мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх асуудлуудыг ярьж байгаа.

Гэтэл уул уурхайн салбар дээр энэ голлох төрийн захиргааны нүд чих болсон энэ гурван байгууллага Ашигт малтмал, газрын тосны газар болоод Гааль, Татварын ерөнхий газруудын мэдээллүүд яагаад ийм хоорондоо тоо хэмжээ нь зөрүүтэй байгаа юм.

Би энд магадгүй ажлын алдаа оноо, эсвэл хийдэл байна уу гэж хараад байгаа юм. Ийм том дүнгээр алдаа үүсэх үндэслэл байхгүй гэж хараад байгаа юм.

Тэгэхээр энэн дээр хэрэв хийдэл байгаа бол үүнийг бид яаж засаж

залруулах ёстой юм бэ? Энэ дээр та нэг Уул уурхайн сайдын хувиар хариулаач.

Бусад татвар болоод Гаалийн ерөнхий газрынхан ч гэсэн хоорондоо мэдээллүүд нь ингээд сая саяар зөрөөд байдаг асуудлыг ер нь яах ёстой юм? Яагаад нэгтгэхгүй байгаад байгаа юм?

Яагаад Та бүхэн бүх юм цахимд шилжээд байхад хоорондоо мэдээллүүдээ нэгтгээд нэг дүнтэй жилийн эцсийн балансар нь бариулчхаж болохгүй байгаад байгаа юм гэдэг асуудал байгаа юм. Зөрүүтэй гараад байгаа юм.

Тэгээд аудитын дүгнэлтээр 1.18-аар энэ гарсан байна гэдгийг харах гээд байгаа юм.

Хоёр дахь нь, 2.3 дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болоод тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнийг Ашигт малтмал, газрын тосны газарт мэдээлж, бүртгүүлж байх үүрэгтэй байгаа. Тухайн тэр тайлагнагч этгээд.

Үүнийг бүртгэх, тайланг нь авах үүрэг нь Ашигт малтмал, газрын тосны газар дээр байгаа юм.

Тэгэхээр энд авч үзсэнээр
-2019 онд 10,
-2020 онд 11,
-2021 онд 9,
-2022 онд 4 хуулийн этгээд бүртгүүлээгүй байна гэсэн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлууд байгаа юм.

Энэ ямар учиртай ийм бүртгэл шилжилттэй холбоотой асуудал юм бол. Хоёр дахь нь.

Гурав дахь нь, аудитын дүгнэлтийн 2.8 дээр одоо бид уг нь Аж

ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дээр эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг нь, хувь оролцоог нь, саналын эрх гэдэг юм уу, тухайн тэр эзэмшигчтэй холбоотой бүх мэдээллүүдийг уг нь бүртгэхээр уг нь заасан.

Аудитын дүгнэлт дээр бас энэ заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна гэсэн зүйл гарч ирж байгаа юм.

Тэгэхээр яагаад жишээ нь юу гэдэг юм, энэ хуулийн хэрэгжилт, бүртгэлжүүлэх хэрэгжилт хангагдахгүй байгаад байна. Бүртгэл яагаад сайжрахгүй байгаа юм. Энэ дээр ер нь ямар асуудлууд байна?

Нэг талдаа юу гэдэг юм аж ахуйн нэгж, байгууллагууд үүргээ биелүүлэхгүй байна уу? Яагаад төрийн зүгээс энэ хяналтаа тавих, хяналтынхаа тогтолцоог сайжруулж чадахгүй байгаад байна вэ? Алдаа, хийдэл хаанаа байгаад байна вэ? Яагаад мэдээллийн зөрүүнүүд үүсээд байна вэ? Хуулийн хэрэгжилтийг яагаад хангаж чадахгүй байна вэ гэдэг нэг ийм асуудлыг асуух гээд байгаа юм.

Дөрөв дэх нь, 2.39 дээр нийт улсын төсвийн татварын өр төлбөр дээр.

Үүний гуравны нэг нь уул уурхайн салбар дээр үүсээд байгаа юм. 1.1 их наяд төгрөгийн татварын өр төлбөр буюу 35.2 хувийг уул уурхайн салбарын татварын өр төлбөр үүсгэж байна.

Энэ дээр Татварын ерөнхий газар ер нь яагаад энд өр үүсээд байгаа юм? Алдаа оноо нь хаанаа байгаад байгаа юм? Энэ салбар яагаад нэг талдаа ийм өр төлбөртэй гараад байгаа юм гэдэг дээр та хэд дүн шинжилгээ хийсэн гэдэг юм уу, энэ дээр анхаарсан, эсвэл гол нөхцөл

байдал, суурь шалтгаан нь хаана байгаа юм. Энэ дээр нэг тайлбаруудыг хэлээч гэсэн зүйл эхлэх гэсэн юм.

Ж.Ганбаатар сайд эхлээд тайлбар өгөх үү?

Ж.Ганбаатар: Түрүүн би Их Хурлын гишүүнийхээ хувиар үг авч байгаад, цаг авч байгаад гишүүнийхээ байр суурийг ярьсан шүү гэдгийг албан ёсоор хэлье.

Сайдын хувьд асуултад хариулъя.

Хоёр асуудал нь Сангийн яам, Татварын ерөнхий газартай холбоотой юм байна.

Ашигт малтмалын хуулийн 48 дугаар зүйлийн 48.6-д манайх 02 сарын 15-наар аж ахуйн нэгжүүдээсээ.

Г.Тэмүүлэл дарга аа,

Аж ахуйн нэгжүүдээсээ бид тайлангаа нэгтгээд, мэдээгээ нэгтгэдэг. Ашигт малтмалын хуульд ийм л хуультай байгаа юм.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүдэд тэр мэдээ нэгтгэж байгаа процесст аж ахуйн нэгжүүд зарим зүйлийг бас мэдээлэхгүй байгаа тийм дутагдлууд байна л даа.

Тэгэхээр бид одоо үүнийг. Бусад энэ зөрүүтэй асуудлуудаар салбар салбар нь өөрсдөө хариулах байх.

Тэр их олон, бараг хорин хэдэн саяар зөрсөн асуудал дээр Ашигт малтмал, газрын тосны газар хариулахад бэлдэж байгаарай.

Тэгэхээр цаашдаа яаж энэ зөрүүг арилгах вэ гэдэг дээр нь манай шинэчилсэн хуулийн төсөл дээр бид энэ

зам явцад нь бид аж ахуйн нэгжүүдийн гаргаж байгаа тэр тайлан мэдээлэлд аудит хийдэг болгох тэр боломжийг хуульд тусгаж өгч байгаа юм.

Энэ бол өөрөө бас аж ахуйн нэгжүүд өөрсдөө л гаргаж өгч байгаа тоо баримтыг манай юу. Манайх чинь тэрийг очоод шалгаад, хянаад, юмыг нь хураадаг юм уу, эсвэл мэдээллийг нь нэгтгэдэг яам биш шүү дээ. Тийм ээ. Өгч байгаа тоо баримтыг л цааш нь дамжуулдаг л яам. Түүнээс бид нарт өөр эрх мэдэл байхгүй.

Г.Тэмүүлэн дарга үүнийг сайн мэдэж байгаа байх.

02 сарын 15-нд Ашигт малтмалынхаа хуулийн дагуу мэдээллээ нэгтгэдэг. Энэ ирж байгаа мэдээлэл өөрөө гаалийн мэдээлэлтэй зөрөх, татварын мэдээлэлтэй зөрөх ийм зүйлүүд байгаа.

Үүнийгээ яаж засах гэж байгаа талаар бид бас хуулийн төсөлдөө тодорхой заачихсан байна гэдгийг хэлье.

Тэр шилжилт хөдөлгөөн дээр зүгээр би сайн мэдэхгүй байна. Зүгээр татварын дарга мэдэж байгаа болов уу гэж бодож байна. Зүгээр өөрсдөө бүртгэл дээр очоод янз янзын хууль бус аргаар ч юм уу, шилжилт хөдөлгөөн хийлгэчихдэг юм шиг байгаа юм. Зарим нь нөөцгүй аж ахуйн нэгжүүд шүү дээ. Одоо яг том олборлогч биш. “Икс” тайлан гаргадаг ч юм уу. Тийм юмнууд л сонсогдож байгаа. Түүгээр зөрж байгаа байх. Хоёрдугаар асуултын хариулт.

Энэ бол тэр бүртгэлийн газрыг сайн хяналттай болгох хэрэгтэй байх. Энэ бол яг манайд өгөхгүйгээр.

Яагаад манайд өгөхгүй байна гэхээр манайд ямар ч нөөц байхгүй,

бүртгэл байхгүй, зүгээр зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд шүү дээ. Тийм ээ.

Хайгуулын юм уу, ашиглалтын. Цаашдаа энэ аж ахуйн нэгжүүдийг ер нь яагаад ингээд 20, 30 жилээр нь байлгаад байдаг юм гэдэг дээр танд бас хариулт өгөхөд бид эдийн засгийн аргаар нь тэмцэнэ гэж байгаа юм. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг бид дэлхийн жишигт нийцүүлж байгаа юм.

Том томоор нь, бүр аймгийнх нь, бараг сумынх нь ихэнхийг нь аваад 20, 30 жил дарж байгаа аж ахуйн нэгжүүд байгаа.

Тийм учраас бид тусгай зөвшөөрлийн төлбөрийг олон улсын жишигт нийцүүлж байгаа. Энэ тохиолдолд том томоор нь аваад тэгээд өөр дээрээ дараад байх асуудлууд хамаагүй багасна. Шилжилт хөдөлгөөний хувьд тэгж хариулья.

Тэгээд ч минут дуусчихлаа. Бусад асуудал нь манай яаманд хамааралгүй. Татвартай холбоотой.

Эцсийн өмчлөгч болоод татварын өр төлбөр гэсэн асуудал байх шиг байна.

Г.Тэмүүлэн: Л.Баярмандал дарга Ашигт малтмал, газрын тосны газрын дарга.

Дараа нь гааль, татварын дарга нар тайлбар өгөөрэй. 4 номер Л.Баярмандал дарга.

Л.Баярмандал: Ашигт малтмал, газрын тосны газар. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья. Энэ хоёр асуултад хариулья.

2022 оны 12 сарын 31-ний байдлаар манайхаас 27 сая 545 мянган

нүүрсийг экспортолсон гэсэн мэдээ гарсан байгаа. Энэ манай веб сайт дээр тавигдсан албан ёсны нээлттэй мэдээ.

Үүнийг хүн болгон ороод үзэх боломжтой. Яах вэ, тэр зөрүү гардгийн хувьд ер нь байнга гардаг юм. Яагаад гэвэл сая бас сайд маань хэллээ. Манайх аж ахуйн нэгжүүдээс авдаг гээд. Тэгээд аж ахуйн нэгжүүд уурхайгаас ачуулаад тэр уурхайгаас ачуулсан мэдээгээ бид нарт өгдөг.

Тэгээд тэр чинь хил хүртэл нөгөө жишээ нь, Цагаанхад дээр овоолгууд байдаг. Гаалийн баталгаат агуулахууд гээд тэнд бас тийм нэг хэдэн сая тонн бас нүүрс байдаг. Мөн машинд ачигдаад хил дээр очерлож байгаа ч гэдэг юм уу яг хилээр гарч амжаагүй боловч уурхайгаас ачигдчихсан байгаа нүүрснүүд бас энэ мэдээнд ордоггүй.

Тийм учраас энэ 2-оос 3 сая тонны зөрүү ер нь байнга гарч байдаг. Энэ байнга ингээд үргэлжлээд явж байдаг процесс учраас ингээд гардаг юм. Энэ нөгөө аж ахуйн нэгжүүдийн өгсөн мэдээллийн үр дүнгээр.

Хоёрдугаар асуулт манайх энэ шилжилт хөдөлгөөнийг бүртгэж авдаг. Тэгэхдээ хуулийнхаа дагуу эхлээд Татварын ерөнхий газар шилжүүлсэн татвараа төлчхөөд Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлчхээд тэгээд тэрнийхээ дараа манайд 14 хоногийн дотор бүртгүүлэх ёстой байдаг.

Бид тэгээд 2021 оны энэ манай “Д03” гэж албан тоотой ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн зөрүүг арилгах, шинэчлэн бүртгэх тухай албан даалгавар гаргасан.

Тэгээд үүнийхээ дагуу 2021 онд 427, 2022 онд 608, 2023 оны 11 сарын 27-ны байдлаар 1200 гаруй аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг шинэчилж бүртгээд байна.

Тэр татвар төлөөгүй байхад бүртгэсэн гэдэг асуудлаар бас энэ ажлын хэсгээс манайд бичиг ирсэн. Тэгээд шүүгээд үзэхэд энэ Засгийн газрын тогтоолоор Эрдэнэс Монгол төрийн өмчит үйлдвэрийн газар тэр нүүрсний тусгай зөвшөөрөл байгаа. Эрдэнэс Баянбогд гээд. Мөн Эрдэнэтэд мөн 6 тусгай зөвшөөрлийг энэ Засгийн газрын тогтоолын дагуу бас шилжүүлсэн байгаа. Тэгээд энэ асуудлууд байсан байна лээ.

Тэр уялдуулахын тухайд манайх энэ Германы Бигэр төслийн хүрээнд Татварын ерөнхий газартай программаа шинэчилж байгаа. Тэгээд шууд хоорондоо мэдээллээ реал таймаар солилцдог болж байгаа. Энэ төсөл хэрэгжээд эхэлчихсэн явж байгаа.

Г.Тэмүүлэн: Татварын ерөнхий газар Б.Заяабал дарга. 7 номер.

Б.Заяабал: Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья. Татварын ерөнхий газар Б.Заяабал.

Аудитын дүгнэлтийн 1.1.18-тай холбоотой асуулт асуусан. Өөрөөр хэлбэл Гаалийн газар, Татварын газар, Ашигт малтмалын газрын энэ тоон мэдээнүүд нь өөр байна гэдэг ийм асуулт асуулаа.

Энэ дээр бүртгэж авч байгаа энэ байгууллага болгон нь өөрийнхөө статистик тоон мэдээнээсээ энэ тоог гаргаж байгаа.

Ашигт малтмалын статистикийнхаа мэдээллээсээ хамаараад, тухайн байгууллагын зорилтоосоо

хамаараад өөр өөр тоон мэдээнүүдийг гаргадаг байгаа.

Жишээлбэл, Ашигт малтмалын газар олборлосон нийт бүтээгдэхүүнийхээ тоо хэмжээгээрээ тайлагнадаг. Уулын ажлын төлөвлөгөө, уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлээрээ энэ олборлосон бүтээгдэхүүний тоо хэмжээг гаргадаг.

Манай гааль бол татвар төлөгчийн гаргасан нийт жинг цэвэр жингээрээ биш өөрөөр хэлбэл чийг агуулсан чийгшилтэй тийм бохир дүнгээр нь гаргаж явдаг байгаа.

Татварын алба дээр цэвэр жингээрээ татвар төлөгч өөрөө тайлагнасан тэр тайлангаас нь гаргаж авдаг.

Тийм учраас энэ гурван жин гурвуулаа хоорондоо тохирдоггүй. Татварын алба, гааль хоёр хоорондоо мэдээгээ байнга солилцож ажиллаж ирсэн.

Үүний дагуу татвар төлөгчийн өр өөрийнх нь тайлагнасан тайлан нь эцсийн дүндээ зөв байна уу, үгүй юу гэдгийг араас нь бид хянаж тайланд буруу байх юм бол бид хяналт шалгалт болон тайлан засуулах мэдэгдлийн дагуу засварыг нь хийж явдаг гэдгийг 1.1.18-тай холбоотойгоор тайлбар өгье.

Сая Л.Баярмандал даргын хэлсэнтэй холбоотойгоор Ашигт малтмалын газрын энэ хөгжүүлэлт хийгдчих юм бол бид бас бодит цагийн горим дээр бүх мэдээллүүдээ аваад явах ийм болно бүрэн байгаа гэдгийг хэлье.

2.3-тай холбоотой лицензийн шилжих хөдөлгөөнтэй холбоотой асуудал

яригдаж байна. Энэ дээр бас хоёр янзын юм байгаад байгаа юм.

Нэгдүгээрт, тэр лиценз нь 100 хувь эзэмшил нь бүрэн солигдох асуудал байгаа.

Хоёрдугаарт нь, тухайн лицензийг эзэмшиж байгаа гурван этгээдийн нэг нь солигдох юм уу, ийм хоёр янзын асуудал байгаа.

Өөрөөр хэлбэл эзэмшигч өмчлөгч нь бүрэн солигдох, эсвэл өмчлөгчийн тодорхой нэг нь солигдох буюу хагас солигдох гэсэн ийм хоёр янзын лиценз шилжилтийн асуудал байгаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар лиценз шилжиж байгаа бол эрх борлуулсны орлого гээд тухайн шилжиж байгаа лиценз, тухайн шилжиж байгаа хувийг тооцож тооцсон дүнгээс нь 10 хувийн татвар авд авдаг.

Ингээд энэ 10 хувийн татвараа төлсөн эсэх талаар зайлшгүй манай татварын албанаас тодорхойлолт авсны дараагаар улсын бүртгэл дээр очиж бүртгэлээ хийлгэдэг.

Дараа нь Ашигт малтмалын газар дээр очиж бүртгэлээ хийлгэдэг ийм харилцаанууд дагаж явдаг.

Энэ 2.3 дээр үүсэж байгаа харилцаа нь татвараас тодорхойлолтоо бүрэн авчихсан. Улсын бүртгэл дээр очоод бүртгэлээ хийлгэчихсэн.

Дараа нь Ашигт малтмалын газар дээр очиж хийлгэх ёстой байтал лиценз дээр нь өөр өөрчлөлт орохгүй, тухайн лицензийг эзэмшиж байгаа “А” компани хэвээрээ байгаа. Тэр дотор байгаа хувь хувьцааны өөрчлөлт орсонтой

холбоотойгоор хийлгээгүй ийм зөрчлүүд илэрсэн байгаа.

Бусад 2.5, 2.6 гэх мэтчилэн зүйлүүд дээр бас манайхаас татварын албанаас тодорхойлолтоо авахгүйгээр шууд очиж бас хийлгэсэн ийм зөрчлүүд гарсан.

Тэгээд аудитын өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох эдгээр байгууллагуудад татварын албанаас албан бичиг явуулж, үүнийг хамтарч засах, ийм холбоотой ажлуудыг зохион байгуулаад явж байна.

Татварын албаны зүгээс хамрагдаагүй татвараас албан ёсоор тодорхойлолтоо аваагүй ийм аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг гаргаад хяналт шалгалтын ажил руугаа бид бас орсон байгаа гэдгийг танилцуулъя.

2.39-тэй холбоотой өрийн.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Заяабал дарга нэмээд тодруулья.

Б.Заяабал: 2.39 дээр уул уурхайн салбарын татварын албанд өртэй байгаа аудитын хяналт шалгалтад явах үед 1.1 их наядын ийм өртэй уул уурхайн салбарынх нь ийм хэмжээний өртэй байна гэсэн ийм тоо мэдээ гарсан байгаа.

Энэ дээр хамгийн зонхилох хувийг жишээлбэл Дарханы төмөрлөгийн үйлдвэр байгаа. Татварын хяналт шалгалт яваад татварын хяналт шалгалтын үр дүнд тавигдсан акт 210 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж тавигдсан. Ингээд өмнөх үлдэгдэлтэйгээ нийлээд ингээд 293 тэрбум төгрөгийн акт байгаа.

Мөн Алтайн хүдэр дээр 77 тэрбум төгрөгийн акт гэх мэтчилэн нийтдээ энэ

уул уурхайн салбар дээр үүссэн 1 их наядын акт байгаа.

Тэгээд татварын өр байнга ингээд тогтвортой байгаад байдаггүй. Байнга хэлбэлзэж явдаг. Нэмэлт шинээр ноогдол үүсэх төдийд нэмэгдэж байдаг. Төлөлт хийгдэх төдийд хасагдаж явдаг ийм байнгын ийм зүйл ээ гэдгийг бас энэ дээр хэлэхийг хүсэж байна.

Уул уурхайн салбар дээр мөн нэмэх нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой аж ахуйн нэгжүүд дээр тавьсан актын асуудал бас энэ дүн дээр орж явж байгаа. Гэх мэтчилэн эдгээр уул уурхайн салбар дээр тавигдсан актын дүн нийтдээ 1.1 их наяд байгаа.

Ер нь энэ уул уурхайн салбар дээр үүссэн энэ их хэмжээний өр үндсэндээ КОВИД-ын хоёр жилийн хугацаанд төрөөс аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тат дэмжих, өр төлөх хугацааг нь хойшлуулах ийм бодлогын хүрээнд эдгээр өрийн асуудал сүүлийн хоёр жилийн хугацаанд нэмэгдсэн байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Тэгэхээр өнөөдөр Төсвийн Байнгын хороогоор бас татварын шинэчлэлтэй холбоотой, уул уурхайн салбарын төвлөрүүлж байгаа орлогын бүрдүүлэлттэй холбоотой Үндэсний аудитын газраас хийсэн хоёр гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууслаа.

Тнгээд энэ хоёр тайланг Үндэсний Аудитын Газраас 2023 оны 9 сарын 29-нд

холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Уул уурхайн яам, Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн байгаа юм.

Тэгэхээр энэ Үндэсний аудитын газраас тавьж байгаа зөвлөмж болоод акт болоод энэ шаардлагуудын талаар энэ хэрэгжилтийг 30 хоногийн хугацаанд хариуг нь хүргүүлсэн байх учиртай байгаад байгаа юм.

Тэгэхээр Та бүхэн 12 дугаар сарын хоёрдугаар долоо хоногт багтаагаад буюу 20-ноос өмнө энэ хэрэгжилтийнхээ явц болоод шийдвэр шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг бас энэ холбогдох байгууллагууд ирүүлэхийг Үндэсний аудитын газар болоод Төсвийн байнгын хороонд ирүүлэхийг нэгдүгээрт даалгаж байна. Даалгаж байна.

Яагаад гэхээр Төрийн аудитын тухай хууль болоод холбогдох хуулиуд дээр орсон өөрчлөлтийн дагуу эргээд энэ аудитаас тавьж байгаа албан шаардлага болоод энэ зөвлөмжийн талаар ямар арга хэмжээ авах цаашид авч хэрэгжүүлэх, залруулах, зөрчил байгаа бол түүнийг арилгах арга хэмжээг авах талаар төлөвлөгөө гаргаж ирүүлэх үүрэгтэй байгаад байгаа.

Хэрэв энэ төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй, тодорхой арилгах эрсдэлийг бууруулах арга хэмжээг аваагүй бол холбогдох албан тушаалтнууд дээр хариуцлага тооцох энэ хуулийн зохицуулалттай болсон байгаа шүү.

Тэгэхээр энэ хуулийн шинэ өөрчлөлт журмууд хэрэгжиж эхэлсэн.

Энэ дээр Та бүхэн маань цааш цаашдаа анхаарч ажиллаарай.

Би нэг зүйлийг онцолж хэлэх гээд байгаа нь Аудитын үндэсний газартай саяын холбогдох энэ хоёр тайлантай холбоотой тайланд хамрагдсан байгууллагууд энэ ирэх долоо хоногийн хугацаанд Та бүхэн нэг хамтарч ажиллаад бүх тоон мэдээллүүдээ нэгтгээдхээч ээ. Бүх мэдээллүүдээ нэгтгээдхээч. Ойлголцлын зөрүү болоод тодорхой зөрчил хийдлүүд байгаа үүнийгээ энэ долоо хоногтоо нэг уулзаад нэн яаралтай нэгдсэн нэг ойлголтод хүрээч ээ.

Тэгээд үр дүнг нь дараа долоо хоногт Төсвийн байнгын хороонд Үндэсний аудитын газар болоод бусад энэ холбогдох байгууллагууд мэдээллүүдээ нэгтгээд тайлангаа Төсвийн байнгын хороонд би бас ирүүлэхийг даалгаж байна.

Тэгээд хоёр долоо хоногийн дараа Төсвийн байнгын хороонд энэ шаардлагатай тохиолдолд Үндэсний аудитын газраас тодорхой арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байгаа бол Төсвийн байнгын хорооноос тодорхой эрх зүйн баримт бичгийг санаачилж боловсруулах эрх байгаа. Нэгдсэн чуулган ч бас оруулж болно гэдгийг хэлэх байна.

Одоо бид нарын хувьд цаашдаа дахиад хэд хэдэн аудитын тайлангууд

байгаа. Ирэх долоо хоногт нэмж хоёр тайланг бид бас нэмж хэлэлцэнэ.

Тэгэхээр ирэх долоо хоногт хэлэлцэх тайлантай холбогдуулаад Та бүхэн өнөөдөр юу гэдэг юм энд үл ойлголцол үүсэж нэгдсэн тоон мэдээлэл нэгтгэхгүй ийм алдаа зөрчлийг гаргахгүй байхаар ирэх долоо хоногийн хоёр тайлантай холбогдуулж энэ долоо хоног бас аудитын газартай хоёрдугаарт, Та бүхэн бас нэгдэж суугаадхаарай.

Ингээд шаардлагатай ирэх долоо хоногийн нэмж хэлэлцэх энэ хоёр тайлангийн хэрэгжилтийг Та бүхэн бас урьдчилж бид нарт танилцуулаад цаашид магадгүй алдаа зөрчил байгаа бол тэрийг хэрхэн залруулах, хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхой болгож байж Байнгын хороонд орж ирээрэй гэсэн үүрэг даалгаврыг Төсвийн байнгын хорооноос Та бүхэнд бас өгч байна.

Ингээд уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн Байнгын хороо хорооны хуралдаанд оролцсон Засгийн газрын ажлын хэсэг болоод Улсын Их Хурлын гишүүдэд бас баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Баярлалаа. Та бүхэнд.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 13 цаг 20 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД